



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 03 дугаар сарын 23
№12 (1407)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

38.	Си Эм Пи Ай” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Татварын ерөнхий газрын харьяа Том татвар төлөгчийн газрын татварын улсын байцаагчид холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0055	647
39.	Ж.Уугантөрийн нэхэмжлэлтэй, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0079	658
40.	“Алтаншогол” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0090	667
41.	“Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0098	678
42.	“Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-ийн нэхэмжлэлтэй, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2026/0001	694

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0055

Улаанбаатар
хот

**“Си Эм Пи Ай” ХХК-ийн нэхэмжлэлтэй,
Татварын ерөнхий газрын харьяа
Том татвар төлөгчийн газрын
татварын улсын байцаагчид холбогдох
захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч: Г.Банзрагч

Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

Шүүгчид: М.Батсуурь

Ц.Цогт

Илтгэгч шүүгч: П.Соёл-Эрдэнэ

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга: Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны
10 дугаар сарын 28-ны өдрийн 128/ШШ2024/0837 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01
дүгээр сарын 29-ний өдрийн 221/МА2025/0079 дүгээр магадлалтай,

Хэргийн оролцогчид: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
Ц.Болор-Эрдэнэ, Г.Ишханд, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Б.Цэнгүүн,
хариуцагч Ц.Энхбаатар, хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч
Х.Алтанхүү нарыг оролцуулан,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт
шүүгчийн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 220 дугаар
хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, “хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол,
тайлбараас өөрөөр хэрэглэсэн” эсэх, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль
хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх гэсэн
үндэслэлээр, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлоор
хянан хэлэлцэв.



ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэлийн шаардлага:

1.Татварын улсын байцаагч нарын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн НА-21220000024 дугаар нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгуулах;

2.Хэргийн нөхцөл байдал: “Си Эм Пи Ай” ХХК-ийн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, 504,786,017 төгрөгийн төлбөр тогтоосон байх бөгөөд нэхэмжлэгч хуулийн этгээд нь 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Худалдах, худалдан авах гэрээ байгуулж, төмрийн хүдрийг улсын хилээр гаргасан, энэхүү гэрээний худалдагч тал: “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК, эрх шилжүүлэгч: Эрээн хотын Шин Руй экспорт импортын компани, Эрх хүлээн авагч: “Си Эм Пи Ай” ХХК байсан буюу худалдагч нь үндсэн гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүнийг Төмөртолгойн уурхайн ам нөхцөлөөр худалдсан тул бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш үүдэн гарах гаалийн болон бусад татвар, хураамж, зардлыг эрх хүлээн авагч болох нэхэмжлэгч хуулийн этгээд хариуцахаар тохирсон байна.

3.Нэхэмжлэгч хуулийн этгээдээс: “ ... Тээвэрлэлтийн үүрэг гүйцэтгэсэн, ашигт малтмал ашигласны төлбөр төлөх үүрэггүй, ачилтын асуудал үүсээд гэрээ байгуулсан. Хилээр гаргахдаа “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн нэрээр гаргах байсан. Цэцийн дүгнэлтийн дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч биш, үндсэн төлбөр төлөгч биш тул нэмэлт төлбөр төлөгч биш, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК дагалдах баялагт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй тул манайх төлөхгүй” гэж,

4.Хариуцагчаас: “ ... Нэхэмжлэгч нь “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-аас төмрийн хүдрийг худалдан авч экспортлосон болох нь гэрээ болон гаалийн мэдээгээр тогтоогдсон. Нэхэмжлэгч нь худалдан авагч буюу Хятад улсын компанийн өмнөөс бүх эрх үүргийг шилжүүлэн авсан. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-иас давхардсан хэсгийг хасаад, зөвхөн нэхэмжлэгчийн хилээр гаргасан хэсэгт татвар тооцсон, төмрийн хүдэр болон дагалдах баялгийн борлуулалтын орлогод ногдох нэмэлт төлбөрийг лабораторийн дүгнэлтийг үндэслэн зах зээлийн үнээр тооцсон” гэж тус тус маргажээ.

5.Анхан шатны шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Үүнд:

5.1.Гаалийн хилээр мэдүүлэг гаргасны үндсэн дээр төмрийн хүдрийг хилээр нэвтрүүлсэн нэхэмжлэгчийг экспортлогч гэж үзсэн нь хууль зөрчөөгүй.

5.2.Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэх үндэслэлээр хүчингүй болсон хууль анх батлагдсан цагаасаа эхлээд үйлчлэлээ алдах нь гагцхүү Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хариуцлагыг хөнгөрүүлэх тохиолдолд хамаарахаар байна. Хуулийн энэ зохицуулалтын дагуу татвар төлөгч эсэхээ зөв тогтоогоогүй татвараа үнэн зөв тайлагнаагүйгээс татварын хууль тогтоомжид үндэслэн ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн татвар ногдуулахад 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс өмнө үйлчилж байсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт хамаарахгүй.

5.3.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-д ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах бүтээгдэхүүний төрлийг заахдаа төмөр, төмрийн хүдэрт ногдуулахаар тогтоосон, харин төмрийн баяжмалыг бүтээгдэхүүний төрөл болгож оруулаагүй байгаа тул шинжилгээгээр тогтоосон төмрийн хүдэр дотор агуулагдах төмөр, хөнгөн цагаан, зэс, цайр, хар тугалга, хүхэр зэргийг агуулагдсан хэмжээгээр нь тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахаар тооцсон энэ хуулийг зөрчөөгүй болно.

5.4.Ийнхүү шинжилгээгээр төмрийн хүдэр доторх элементүүд ингэж тодорхой хувь хэмжээгээр нэгэнт тогтоогдсон байхад хариуцагч татварын улсын байцаагч нар Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-т заасныг баримтлан эдгээр бүтээгдэхүүнүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хувь хэмжээг элемент тус бүрд харгалзуулан тогтоосон нь хууль зөрчөөгүй байна.

6.Давж заалдах шатны шүүх дараах дүгнэлтээр шийдвэрийг хэвээр үлдээсэн:

6.1.Улсын дээд шүүхийн 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 47 дугаар тогтоолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх үүрэг үүсгэж буй ашигт малтмал экспортолсон этгээд гэх ойлголтын хууль зүйн агуулга нь ашигт малтмалыг газрын хэвлийгээс салган авч гадаад улс руу худалдсан, худалдахаар ачуулсан этгээдийг хамааруулах агуулгатай, харин худалдах, худалдан авах харилцааны явцад тухайн ашигт малтмалыг зөөсөн, тээвэрлэсэн этгээдэд хамааралгүй гэж дүгнэснээс үзэхэд нэхэмжлэгчийн тухайд 50.000 тн төмрийн хүдрийг худалдан авч, улмаар тээвэрлэж, экспортод гаргасан байх тул дээрх хуульд заасан үүргийг хүлээнэ.

6.2.“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-иас дээрх гэрээнүүдийн дагуу худалдан авч экспортолсон нийт 94.631,056.6 кг төмрийн хүдрийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох борлуулалтын үнэлгээг зөвхөн төмрийн хүдрийн тооцооллоор хийж, дагалдах баялгийн агуулгад



уг төлбөрийг тооцож ногдуулалгүйгээр 2019, 2020 оны Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангаар тайлагнаж, татварын удирдлагын нэгдсэн системд баталгаажуулсныг татварын хяналт шалгалтаар илрүүлж, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2, 47.3, 47.6, Засгийн газрын 2019 оны 342, 465 дугаар тогтоолоор батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах журам”-д тус тус заасны дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн анх худалдахдаа суутгасан 402.0 сая төгрөгийг хасч, нөхөн ногдуулалтын актаар тогтоосон төмрийн хүдрийн дагалдах бусад ашигт малтмалд ногдох төлбөрийг нэхэмжлэгч төлөх үүрэгтэй.

6.3.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн анхны зохицуулалтаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч байсныг уг заалтад 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж, 2019 оны 03 дугаар сарын 26, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гадна ашигт малтмал экспортолсон этгээд байхаар болсон тул “Си Эм Пи Ай” ХХК нь Худалдах, худалдан авах гэрээний бүх эрх, үүргийг шилжүүлж авах байдлаар, мөн Худалдах, худалдан авах гэрээг шууд байгуулах байдлаар тус тус “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-иас олборлосон нийт 94,631,056.6 кг төмрийн хүдрийг 2019, 2020 онд экспортолсон нь хэрэгт авагдсан баримтаар хангалттай тогтоогдсон энэ тохиолдолд төмрийн хүдрийн дагалдах баялагт ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нэхэмжлэгчээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн нь Ашигт малтмалын тухай хуульд нийцсэн.

6.4.Төмрийн хүдрийн дагалдах ашигт малтмалын бүтээгдэхүүнд борлуулалтын үнэлгээний 5 хувиар ногдуулсан төлбөрийн тал буюу 2.5 хувьд хамаарах хэсгийг төмрийн хүдрийг дотооддоо худалдсан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-иас шаардах эрхтэй гэж үзвэл иргэний журмаар маргах эрхийг энэхүү шийдвэр, магадлалаар хязгаарлахгүй болно.

7.Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1.Төмрийн хүдэрт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь төмрийн хүдрийг тээвэрлэн улсын хилээр гаргасан “нэхэмжлэгч хуулийн этгээд” биш, харин түүнийг гадаад улсад бүртгэлтэй компанид худалдсан этгээд, эсхүл дотоодын зах зээлээс худалдан авч өөрөө экспортод гаргаж байгаа этгээд буюу тухайн ашигт малтмалыг захиран зарцуулах эрх бүхий этгээд байх тул “... төмрийн хүдэр худалдаагүй, худалдах зорилгоор ачуулаагүй, Хятад Улсын компани худалдан авсан төмрийн хүдрийг тээвэрлэх ажил гүйцэтгэсэн компанийг бүхэлд нь экспортлогч” гэж үзсэн нь хуульд нийцээгүй.

7.2.Хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1 дэх заалт нь “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч”-ийг тодорхойлсон агуулгагүй, борлуулалтын үнэлгээг хэрхэн тогтоохыг журамласан агуулгатай тул уг зохицуулалт нь мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д тодорхойлсон “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч”-д хамааралтай буюу тухай цаг хугацаанд ашигт малтмал худалдаагүй, худалдахаар ачуулаагүй, ашиглаагүй этгээдэд хамаатуулан хэрэглэхгүй.

7.3.Ашигт малтмал экспортод гаргасан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх хуулийн зохицуулалт 2019 оны 6, 7 дугаар сард байгаагүй, хариуцагч нар Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.1-д “экспортод бүтээгдэхүүн гаргасан бол” гэснийг үндэслэж, маргаан бүхий нөхөн ногдуулалтын актаар 2019 оны 6, 7, 8, 9, 10 дугаар сард ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дутуу төлсөн гэх агуулгаар акт тавьсан нь үндэслэлгүй байна.

7.4.Үндсэн хуулийн цэцийн Дунд суудлын хуралдааны 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлтээр “үндсэн хуулийн заалтыг зөрчсөн” гэх үндэслэлээр, үйлчлэлийг нь 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн, Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдааны 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хуулийн энэ хэсгийн “ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээднь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө” гэсэн заалтыг хүчингүй болгосон байна.

7.5.Үндсэн хууль зөрчсөн аливаа хууль, бусад эрх зүйн баримт бичиг агуулгын хувьд “анхнаасаа үйлчлэлгүй” буюу хүчин төгөлдөр бус байх тул түүнд үндэслэж гаргасан захиргааны аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь хууль ёсны үндэслэл бүхий бус” байх үр дагавартай. Иймд шүүхээс нэхэмжлэгч хуулийн этгээдийг бүхэлд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч гэж үзсэн нь үндэслэлгүй болно.

7.6.Тус маргаан бүхий хугацаанд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь олборлосон бүтээгдэхүүндээ нэг ч төгрөгийн дагалдах баялгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй ба уг төлбөрийг татварын улсын байцаагч нар хууль ёсны гэж үзсэн бөгөөд энэ талаар огт дүгнэлт хийгээгүй ба дүгнэлт хийхээ татгалзаж шийдвэрлэсэн. Гэтэл тус компани олборлосон бүтээгдэхүүний зөвхөн төмрийн хүдэртээ л ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн байгааг хүлээн зөвшөөрсөн нөхцөлд тухайн бүтээгдэхүүнийг худалдан авсан аливаа хуулийн этгээдэд бусад дагалдах бүтээгдэхүүнд төлбөр ногдуулж байгаа нь хуульд заасан тодорхой байх, болон шударга байх зарчимд нийцэхгүй байна.



ХЯНАВАЛ:

8.Хяналтын шатны шүүхээс дараах үндэслэлээр шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, маргаан бүхий татварын актыг түдгэлзүүлж, дахин шинэ акт гаргахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэлээ.

9.Тогтоогдсон үйл баримтын тухайд, нэхэмжлэгч хуулийн этгээд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй бөгөөд Дархан-Уул сумын Хонгор суманд байрлах Төмөртолгойн төмрийн хүдрийн уурхайгаас гэрээний үндсэн дээр 2019 онд 40,787 тонн, 2020 онд 53,843 тонн төмрийн хүдрийг улсын хилээр гаргасан, энэхүү тоо хэмжээтэй хэргийн оролцогчид маргаагүй байна.

10.Харин нэхэмжлэгч хуулийн этгээд нь “гэрээний дагуу тээвэрлэгчийн үүрэг гүйцэтгэсэн, төмрийн хүдэр худалдаж аваагүй, дамжуулан борлуулаагүй тул ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч биш, мөн дагалдах баялгийн төлбөрийг төлөх үүрэггүй” гэж маргаж байна.

11.Түүнчлэн нэхэмжлэгч хуулийн этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан (ТТ-15) гаргахдаа 2019 онд борлуулалтын нийт үнэлгээнээс 608,244,293 төгрөгийн үндсэн төлбөр, 2020 онд 403,935,742 төгрөгийн үндсэн төлбөр төлөхөөр тайлагнаснаас 808,244,293 төгрөгийг төлсөн үйл баримт тогтоогджээ.

12.Энэ хэргийн тухайд, хяналтын шатны шүүхээс хууль зүйн дүгнэлт өгөх шаардлагатай асуудал нь нэхэмжлэгч хуулийн этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны үндсэн төлбөр төлөх үүрэгтэй эсэх, мөн дагалдах баялагт ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг хэрхэн тооцох агуулгатай байна.

13.Үндсэн хуулийн цэцийн тогтоолыг энэхүү маргаанд хэрэглэх тухайд:

14.Ашигт малтмалын тухай хуулийн (2006 он) 47 дугаар зүйлийн 47.1-д “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлнө” гэж зааснаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар хуульчилсан байсныг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлаас “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ...” ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар өөрчлөн найруулж, ашиглалтын

тусгай зөвшөөрөл эзэмшигч эсэхээс үл хамааран ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөхөөр өргөжүүлэн зохицуулсан.

15.Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар дүгнэлтээр дээрх 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өөрчлөн найруулсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг “Үндсэн хууль зөрчсөн” болохыг тогтоож, Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор тус зүйлийг хүчингүй болгож, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2-ийг “ашигт малтмал экспортолсон этгээд” ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөхөөр өөрчлөн найруулсан бөгөөд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар тус зохицуулалтыг 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заажээ.

16.Үүнээс үзвэл 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өөрчлөн найруулсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосон байх тул Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д “ашигт малтмал экспортолсон этгээд” гэх зохицуулалт тусгагдах хүртэл буюу 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс өмнөх хугацаанд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч бус этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх эрх зүйн үндэслэлгүй байна.

17.Энэ талаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолтой, “Эйч Эн Эс Жи” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэг, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 131 дүгээр тогтоолтой “Гэгээн хэлхээ” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэг, 132 дугаар тогтоолтой “Арвин хүдэр” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэгт “... нэгэнт хүчингүй буюу эрх зүйн үйлчлэлгүй болсон хуулийг үндэслэсэн татвар төлөх үүрэг үүсэхгүй, хууль дээдлэх зарчимд нийцэхгүй” гэж дүгнэж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоосон байхад анхан болон давж заалдах шатны шүүхээс уг хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол тайлбараас өөрөөр тайлбарлан хэрэглэж, хууль хэрэглээний зөрүү үүсгэсэн байна.

18.Иймд нэхэмжлэгч хуулийн этгээд нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч биш байсан буюу 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх үүрэг хүлээхгүй, харин 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс хойшхи хугацаанд экспортолсон төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх үүрэгтэй, энэ цаг хугацааны шалгуурыг баримтлан татварын улсын байцаагч нараас тооцооллыг хийж, татварын нөхөн ногдуулалтын актыг дахин үйлдэх шаардлагатай.



19.Хариуцагчийн “төлбөртэй холбоотой гэрээний 2.1.9-д зааснаар нэхэмжлэгч бүх төлбөрийг хариуцахаар тохирсон байсан” гэх тайлбарыг хүлээн авах үндэслэлгүй, 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн Худалдах, худалдан авах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх гэрээний 2.1.9-д “Худалдагч нь Үндсэн гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүнийг Төмөртолгойн уурхайн ам нөхцөлөөр худалдсан тул бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш үүдэн гарах гаалийн болон бусад татвар, хураамж зардлыг Эрх хүлээн авагч хариуцна”(“Си Эм Пи Ай” ХХК) гэж заасан нь хуулиар тогтоосон татвар төлөх үүргийг өөрчлөх, өөр бусдад шилжүүлэх эрх зүйн үр дагавар үүсгэхгүй буюу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээс чөлөөлөгдөх хууль зүйн үр дагавар үүсгэхгүй, нөгөө талаар татварын улсын байцаагч нараас хуульд нийцүүлэн, өөрийн эрх хэмжээний хүрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлбөл зохих этгээдэд холбогдуулан төлбөр тогтооход шүүхийн энэхүү тогтоол саад болохгүй.

20.Нэхэмжлэгчийн “тээвэрлэгчийн үүрэг гүйцэтгэсэн” гэх тайлбар бодит байдалд нийцээгүй, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн төлбөрийн жагсаалт, өглөг авлагын дэлгэрэнгүй тайлан, харилцагчийн дансны хуулга зэргээс¹ үзэхэд “Си Эм Пи Ай” ХХК нь “хүдрийн үнэ” гэж мөнгө шилжүүлсэн болох нь тогтоогдсон байх тул тээвэрлэгч гэж үзэхгүй.

21.Дагалдах баялагт ногдох төлбөрийн тухайд,

22.“Си Эм Пи Ай” ХХК нь 2019 онд 40,787 тонн ашигт малтмал экспортод гаргаснаас итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтэд 27,296 тонн нь 56%-ийн агуулгатай төмрийн хуурай хүдэр, 13,490 тонн нь 60%-ийн агуулгатай хуурай хүдэр, 2020 онд 53,843 тонн ашигт малтмал экспортод гаргаснаас 30,428 тонн нь 56%-ийн агуулгатай хуурай хүдэр, 23,415 тонн нь 60%-ийн агуулгатай хуурай хүдэр² байсан, харин дагалдах баялгийн тухайд, хилээр гаргасан хэмжээ тус бүрээр, жишээлбэл, Гаалийн төв лабораторийн 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн дүгнэлтэд³ “тус төмрийн хүдэрт хөнгөн цагаан 0.76 хувь, зэс 278.45 мг/кг, цайр 167.85 мг/кг тус тус агуулагдаж байна”, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тооцоололд⁴ “зэс 340.50 мг/кг, цайр 142.00 мг/кг, хөнгөн цагаан 0.73%” гэх зэргээр тодорхойлсон, хариуцагчаас “нэмэлт төлбөр 455,474,077 төгрөг” гэсэн байх боловч шинжээчийн дүгнэлтэд⁵ “2019 он, мөнгө 75,625, зэс 13,729,956, хар тугалга 56,026, цайр 3,450,434, хөнгөн цагаан 73,354,582, 2020 онд мөнгө 2,382,336, зэс 22,008,795, хар тугалга 136,200, цайр 3,078,154, хөнгөн цагаан 106,732,181, нийт төлбөр 225,004,294 гэсэн, тооцоолол⁶ гэсэн баримтад “нэмэлт төлбөр 473,743,479” гэжээ.

¹ 2 дахь хавтаст хэргийн 103-115 дугаар тал

² 1 дэх хавтаст хэргийн 34 дүгээр тал

³ 1 дэх хавтаст хэргийн 111 дүгээр тал

⁴ 2 дахь хавтаст хэргийн 151-152 дугаар тал

⁵ 3 дахь хавтаст хэргийн 4 дүгээр тал

⁶ 3 дахь хавтаст хэргийн 27 дугаар тал

23.Нэхэмжлэгч хуулийн этгээдээс “дагалдах баялагт ногдох төлбөрийг яаж бодсон аргачлал, тооцоолол тодорхойгүй, актад энэ талаар заагаагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд дагалдах баялгийн төлбөрийг төлөх үүрэгтэй, манай компанийн үүрэг биш” гэж маргасан байх бөгөөд маргаан бүхий татварын нөхөн ногдуулалтын актад дагалдах баялагт ногдох төлбөрийг хэрхэн тооцсон аргачлал тодорхойгүй, үндэслэлээ маргаан бүхий актад тодорхой заагаагүй, энэ талаарх нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлыг хангах үндэслэлтэй байна.

24.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5-д “Энэ хуулийн 47.3.3-т заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингөөс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно” гэж, 47.8-д “Энэ хуулийн 47.5, 47.17-д заасан хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг геологи, уул уурхайн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасныг маргааны үйл баримтад холбогдуулан хэрэглэхэд, маргаан бүхий татварын улсын байцаагчийн актын дагалдах баялагт төлбөр тогтоосон аргачлал, зарчим тодорхойгүй, дагалдах баялгийн нэгж агуулгын хувь, нэгжийн үнэлгээ, борлуулалтын үнэлгээ тодорхойгүй байх тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11-т зааснаар маргаан бүхий актыг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж, дахин шинэ акт гаргахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэлээ.

25.Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоолоор баталсан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмын 2.8-д “Нүүрснээс бусад ашигт малтмалын бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тодорхойлсон агуулгын цэвэр хувь, хэмжээнд үндэслэн үндсэн болон дагалдах металл, эрдэс бүтээгдэхүүн тус бүрээр тооцно” гэж, 3.2-д “Ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах металл болон эрдэс бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.5 дахь хэсэгт заасан боловсруулалтын түвшний “бүтээгдэхүүн” ангиллын хувь хэмжээгээр, 47.17 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүний нэр төрлийн “эцсийн бүтээгдэхүүн” ангиллын хувь хэмжээгээр тус тус тооцож ногдуулна” гэж заажээ. Түүнчлэн Татварын ерөнхий газрын даргын 2012 оны 322 дугаар тушаалаар баталсан Уул, уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцох аргачлалыг энэхүү маргаанд хэрэглэх эсэх, хэрэв хэрэглэх бол хууль зүйн үндэслэлээ тодорхой тайлбарлах шаардлагатай байна.



26.Тодруулбал, энэ тохиолдолд дагалдах баялгийн ангиллын хувь хэмжээний тооцоолол тодорхойгүй буюу хилээр гаргасан төмрийн хүдэрт дагалдах баялгийн хувь, жишээлбэл “хөнгөн цагаан 0.76”-ийг тооцохдоо олон улсын зах зээлийн 100%-ийн ангилалтай хөнгөн цагаанаас тооцсон, эсхүл 0.76%-аас тооцсон, эсхүл нийт төмрийн хүдрийн 100%-иас тооцсон эсэх, энэ тооцоолол нь 94,630 тонн төмрийн хүдрийн нийт хэмжээнд нэмэгдсэн, эсхүл хасагдсан эсэх нь ойлгомжгүй, жишиг үнийн мэдээлэлд заасан агуулгын хувь, хилээр гаргасан бүтээгдэхүүний агуулгын хувь, хэмжээнд хэрхэн хувь тэнцүүлж бодсон, энэ нь Засгийн газраас тогтоосон журам болон аргачлалд хэрхэн нийцэж байгаа талаар тодорхой үндэслэлийг актад бичих нь “татвар ойлгомжтой тодорхой” байх зарчимд нийцнэ.

27.Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимаас энэхүү маргааныг “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” гэсэн үндэслэлээр хүлээн авч, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн буюу “дагалдах баялгийн төлбөрийг хэн төлөх, төлбөр төлөх зарчим, аргачлалыг хэрхэн тооцох” талаар хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох шаардлагатай гэж үзсэн, тухайн тохиолдолд “хилээр гаргасан дагалдах баялагт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх үүрэгтэй, гэвч төлбөрийн хэмжээг хэрхэн тооцсон журам, аргачлалыг тодруулах шаардлагатай, уг нөхцөл байдал тодорхой бус байх тул хууль хэрэглээний хувьд хяналтын шатны шүүхээс эцэслэн дүгнэх боломжгүй байна.

28.Дээрх үндэслэлүүдээр шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 128/ШШ2024/0837 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 221/МА2025/0079 дүгээр магадлалыг “тогтоох” хэсгийн дэх 1 заалтыг “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.5, 47.8 заасныг баримтлан Татварын ерөнхий газрын, том татварын төлөгчийн газрын улсын байцаагч нарын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн НА-2122000024 дугаартай нөхөн ногдуулалтын актыг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж, дахин шинээр акт үйлдэхийг хариуцагчид даалгасугай. 2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.6-д зааснаар шүүхээс тогтоосон хугацаанд хариуцагчаас шинэ акт гаргаагүй бол уг нөхөн ногдуулалтын акт хүчингүй болохыг дурдсугай” гэж өөрчилсүгэй.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчээс хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА

ШҮҮГЧИД

М.БАТСУУРЬ

Ц.ЦОГТ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 09 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0079

Улаанбаатар
хот

Ж.Уугантөрийн нэхэмжлэлтэй, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч: Х.Батсүрэн

Танхимын тэргүүн: Д.Мөнхтуяа

Шүүгчид: М.Батсуурь

П.Соёл-Эрдэнэ

Илтгэгч шүүгч: Г.Банзрагч

Нарийн бичгийн дарга: Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
05 дугаар сарын 08-ны өдрийн 128/ШШ2025/0328 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 06
дугаар сарын 18-ны өдрийн 221/МА2025/0416 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогчид: Нэхэмжлэгчийн өмгөөлөгч
Б.Дагважанцан, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ө.Нармандах
нарыг оролцуулж,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн
хуралдааны 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 001/ШХТ2025/0319
дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэл
байгаа эсэхийг нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан
гомдлоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага:

Ж.Уугантөр нь Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт холбогдуулан “Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн нас барсан тэтгэвэр авагчийн 20 хувийг Ж.Уугантөрд олгохгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, нас барсан тэтгэвэр авагчийн 20 хувийг буюу 359,501 төгрөгийг Ж.Уугантөрд олгохыг даалгах” нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

2.Хэргийн нөхцөл байдал:

2.1.Ж.Уугантөр нь 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт хандан Ц.Сосорбурамын тэтгэврийн 20 хувийг өөрийн тэтгэвэр дээр нэмэгдүүлэн авах хүсэлтийг гаргасан боловч захиргаа хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзсан байна.

3.Нэхэмжлэгчээс дараах үндэслэлээр маргаж байна. Үүнд:

“... Миний бие Ц.Сосорбурамтай 1989 онд гэр бүл болж 35 жил хамт амьдарсан. Эхнэр Ц.Сосорбурам нь 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр өвчний улмаас нас барсан. Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэврээ нэмэгдүүлэн авах хүсэлтийг Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт гаргасан боловч огт хүлээж авдаггүй, хүсэлт шийдвэрлэдэггүй эс үйлдэхүй гаргасан. Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлээгүйн улмаас миний өндөр насны тэтгэврээ нэмэгдүүлэн авах хуулиар олгогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагуудыг бүгдийг хангаж байгаа, хариуцагчаас гэр бүлийн аль нэг гишүүн нь нас барахад үлдсэн гишүүн нь тэтгэвэр тогтоолгосон байх шаардлагатай гэж тайлбарлаж байгаа нь үндэслэлгүй. Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү” гэжээ.

4.Хариуцагчаас нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “... Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/82 дугаар зөвлөмжийн 2.6-д заасан шалгуурыг хангасан тохиолдолд тэтгэврийн нэмэгдлийг нас барсан тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас тооцож олгоно. Ц.Сосорбурам нь 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр нас барсан. Дээрх цаг хугацаанд Ж.Уугантөр нь тэтгэвэр тогтоолгох шаардлага хангаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож аваагүй байсан учир хариуцагчийн зүгээс татгалзсан. Дээрх зөвлөмжид заасан “... Тухайн гэр бүлийн хоёр гишүүн хоёулаа нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх” шаардлагыг хангахгүй байна. Иймд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.



5.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 128/ШШ2025/0328 дугаар шийдвэрээр “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Ж.Уугантөрийн гаргасан “Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн нас барсан тэтгэвэр авагчийн 20 хувийг Ж.Уугантөрд олгохгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, нас барсан тэтгэвэр авагчийн 20 хувийг буюу 359,501 төгрөгийг Ж.Уугантөрд олгохыг даалгах” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож” шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд:

5.1.“... Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан тусгай зохицуулалтад хамрагдахад мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна, мөн зүйлийн 9.3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01/82 дугаар зөвлөмжийн 2.6-д зааснаас үзвэл гэр бүлийн гишүүн болох нөхөр эсхүл эхнэр хоёул өндөр насны тэтгэврээ тогтоолгон, нийгмийн даатгалын сангаас (нэг төрлийн сан) өндөр насны тэтгэвэр хамт авдаг нөхцөлийг хангасан тохиолдолд дээрх хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан нас барагчийн тэтгэврийн 20 хувийг түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэвэр дээр нэмэгдүүлэн олгохоор байна. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч Ж.Уугантөр нь өөрийн (нас барсан) эхнэрийн хамт хоёул өндөр насны тэтгэвэр авч байсан тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан тусгай зохицуулалтад хамрагдах боломжтой.

5.2.Нэхэмжлэгч нь өөрийн эхнэр болох Ц.Сосорбурамыг нас барахад Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан “... 60 насанд хүрсэн эрэгтэй ...” гэх өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүсэх насны хязгаарт хүрээгүй байсан, өөрийн эхнэр болох Ц.Сосорбурамыг нас барснаас хойш 3 сарын дараа өндөр насны тэтгэврээ тогтоолгосон, өөрийн (нас барсан) эхнэрийн хамт хоёул өндөр насны тэтгэвэр авч байгаагүй болох нь баримтаар тогтоогдож байх тул хариуцагчаас нэхэмжлэгчийн гаргасан тэтгэвэр нэмэгдүүлэх хүсэлтийг шийдвэрлэхгүй байгаа нь үндэслэлтэй, хариуцагчийн энэ үйл ажиллагааг хууль бус гэж буруутгах боломжгүй ...” гэх зэргээр дүгнэжээ.

6.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 221/МА2025/0416 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

7.Нэхэмжлэгчийн өмгөөлөгч Б.Дагважанцан хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1.“... Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2-т заасан хуулиар тогтоосон хоёр шаардлагыг нэхэмжлэгч нь аль алийг нь хангадаг. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч нь (нас барсан) эхнэртэйгээ гэрлэлтээ бүртгүүлсэн, 20 түүнээс дээш жил хамт амьдарсан үйл баримт тогтоогддог. Харин шүүх Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/82 дугаар зөвлөмжийн 2.6-д заасан шаардлагыг тайлбарлахдаа “гэр бүлийн гишүүн болох нөхөр эсхүл эхнэр хоёул өндөр насны тэтгэвэр хамт авдаг нөхцөлийг хангасан байх тохиолдолд энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан нас барагчийн тэтгэврийн 20 хувийг түүний нөхөр эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэвэр дээр нэмэгдүүлэн олгохоор байна” гэсэн нь бодит байдалтай нийцэхгүй, зөвлөмжийг буруу тайлбарласан. Нэхэмжлэгч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байхдаа өндөр насны тэтгэвэр нэмэгдүүлэх хүсэлтийг гаргаагүй.

7.2.Өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байхдаа (нас барсан) эхнэрийн тэтгэврийн 20 хувийг нэмэгдүүлэх талаар хүсэлт гаргасан бол хариуцагчийн татгалзал, шүүхийн шийдвэрийг буруутгах үндэслэлгүй. Харин нэхэмжлэгч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосны дараа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан өндөр насны тэтгэвэр нэмэгдүүлэх хүсэлт гаргасныг шүүх анхаарах нь зүйтэй. Нөгөөтээгүүр мөн адил Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01/82 дугаар зөвлөмжийн 2.6-д заасан “... Тухайн гэр бүлийн хоёр гишүүн хоёулаа нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх” гэсэн шаардлагыг хангаж байна.

7.3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01/82 дугаар зөвлөмжид “гэр бүлийн гишүүн болох нөхөр эсхүл эхнэр буюу гэр бүлийн аль нэг гишүүн нас барахад нөгөө нь тэтгэвэр тогтоолгоогүй бол цаашид олгогдохгүй” гэсэн утга агуулга тусгагдаагүй. Нэхэмжлэгч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон үйл баримт тогтоогдож байх тул зөвлөмжид заасан шаардлагыг хангасан. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй байх тул хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж өгнө үү” гэжээ.

8.Хариуцагч тал “Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал үндэслэлтэй тул хэвээр үлдээж өгнө үү” гэсэн агуулгатай тайлбарыг өгөв.

9.Хяналтын шатны шүүх нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлыг “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд



нийтлэг ач холбогдолтой” үндэслэл байгаа эсэхийг хянан хэлэлцэхээр хүлээн авсан болно.

ХЯНАВАЛ:

10.Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах үндэслэлтэй.

11.Энэ хэргийн тухайд, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгтэй холбоотой эрх зүйн шинэ маргаан байх тул хяналтын шатны шүүхээс хууль хэрэглээг тогтооход ач холбогдолтой гэж үзлээ.

12.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд доор дурдсан нөхцөлийг хангасан түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ.”, 9.1.1-д “Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар бүртгүүлсэн”; 9.1.2-т “20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан” гэж заажээ.

13.Үүнээс үзвэл, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний нөхөр, эсхүл эхнэр нь шаардлага хангасан тохиолдолд өндөр насны тэтгэврээ нэмэгдүүлэх эрхтэй болжээ.

14.Нэхэмжлэгч Ж.Уугантөр нь иргэн Ц.Сосорбурамтай 1989 оны 07 дугаар сарын 31-ний өдөр гэрлэлтээ бүртгүүлж, 35 жил хамт амьдарсан. Эхнэр Ц.Сосорбурам нь 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч байгаад 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр нас барсан. Үүнээс хойш 3 сар хагасын дараа буюу 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр түүний нөхөр Ж.Уугантөр нь өндөр насны тэтгэвэр тогтоолгож, улмаар дээрх хуулийн шаардлагыг хангасан гэж үзэж, өөрийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт хандсан боловч татгалзсан хариу авсан байна.

15.Хариуцагч татгалзлын үндэслэлээ “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 болон уг хуулийг хэрэгжүүлэх тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/82 дугаар зөвлөмжийн дагуу “... Тухайн гэр бүлийн хоёр гишүүн хоёулаа нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх” шаардлагатай, иргэн Ж.Уугантөр нь эхнэр Ц.Сосорбурамыг нас барах үед өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байсан тул шаардлага хангахгүй” гэж тайлбарлажээ.

16.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд доор дурдсан нөхцөлийг хангасан түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ.” гэсний “нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэвэр” гэсэн харьяалахын тийн ялгалтай нэр үгийг цаг хугацаатай холбон, “тухайн нөхөр, эсхүл эхнэр нь тэтгэвэр авагчийг нас барах үед буюу өмнө нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх” гэж тайлбарлах боломжгүй. Хуулийн энэ томъёолол нь тухайн агуулгыг шууд илэрхийлэхгүй байх тул үг зүйн аргаар тайлбарлах боломжгүй.

17.Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Энэ хуулийн 9.2-т заасан тэтгэврийн нэмэгдлийг тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн олгоно” гэснийг нэмэгдэл тэтгэвэр авахыг хүсэж буй этгээдэд тавигдах “тусгай шаардлага” гэж үзэхгүй. Учир нь уг хэсэг нь хуулийн системчлэлийн хувьд нэмэгдэл тэтгэвэр авагчид тавигдах шаардлагыг зохицуулсан 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 9.1.1, 9.1.2 дахь заалтаас тусдаа, зорилгын хувьд нэмэгдэл тэтгэвэр олгох цаг хугацааг зохицуулжээ.

18.Хууль тогтоогчийн хүсэл зоригийг тодруулах зорилгоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хэлэлцсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10, 06 дугаар сарын 20, 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 23, 29, 07 дугаар сарын 07-ны өдрийн Нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг судлан үзэхэд хууль тогтоогчийн зүгээс холбогдох зүйл заалтыг (9 дүгээр зүйлийн 9.1, 9.2) хэрхэн ойлгох талаар, тухайлбал өндөр насны тэтгэвэр авагч нас барах үед түүний нөхөр, эсхүл эхнэр нь мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх ёстой гэх агуулгаар тухайлан хэлэлцээгүй, тодорхойгүй байна.

19.Ийнхүү хууль тогтоогчийн хүсэл зорилгыг түүхчлэх аргаар тодорхойлох боломжгүй байх тул хуулийн зорилгоор нь буюу “объектив телеологи”-ийн аргаар тайлбарлах нь зүйтэй. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн зорилго нь нас барагчийн нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэх буюу үргэлжлүүлэн олгоход чиглэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, уг хуулийн зорилго нь хуульд заасан шаардлагыг хангасан (9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.2) нас барагчийн нөхөр, эсхүл эхнэр нь өөрөө хуульд заасан шаардлагыг (нас, ажилласан жил, шимтгэл төлсөн байдал гэх мэт) хангаж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд тэтгэврээ нэмэгдүүлэх боломжийг олгосноос бус цаг хугацааны хувьд хэзээ өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нь (тухайлбал гэр бүлийн хүн нь нас барахаас өмнө нь эсхүл хойно нь) ач холбогдолгүй, хуулийн зорилгыг ингэж тайлбарлах боломжгүй юм.



20.Түүнчлэн, өмнө нь үйлчилж байсан 2015 оны Хамтын тэтгэврийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийн үйлчлэлд дараах нөхцөлийг хангасан иргэн хамаарна.”; 4.1.1-д “нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр эсхүл цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний 15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр эсхүл нөхөр”; 4.1.2-т “хамтын тэтгэвэр авагч нь 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй Монгол Улсын иргэн байх” гээд, 4.2-т “Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний эхнэр эсхүл нөхөр нь энэ хуулийн 4.1.2-т заасан насанд хүрээгүй тохиолдолд түүнд олговол зохих хамтын тэтгэврийг тухайн насанд хүрсэн үед нь олгож эхлэх бөгөөд энэ эрх нь түүний эхнэр эсхүл нөхрийг нас барснаас хойш тав хүртэлх жилийн хугацаанд хадгалагдана” гэж заасан. Өөрөөр хэлбэл, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т гэр бүлийн хүнд нь насны шаардлага (энэ нь өндөр насны тэтгэвэрт гарах насны зохицуулалт гэж ойлгогдохоор байна) тавьсан боловч 4.2 дахь хэсгээр насны шаардлага хангаагүй ч тухайн насанд хүрсэн тохиолдолд хамтын тэтгэвэр авах эрхтэй байхаар (5 хүртэлх жилийн хугацаанд) заасан байжээ.

21.Дээрх хуулийн зохицуулалтын агуулга, зорилго нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд тусгагдсан байх бөгөөд ингэхдээ хууль тогтоогч насны шалгуурыг нь хасаж, харин “гэр бүлээ бүртгүүлсэн байх”, “20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан байх” гэсэн хоёр шаардлагыг л (9.1.1-9.1.2-т) заасан бөгөөд үүнийг хангасан нас барагчийн нөхөр, эсхүл эхнэр нь тэтгэврээ нэмэгдүүлэх эрхтэй байхаар тодорхой зохицуулжээ. Гэтэл хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан ерөнхий нөхцөлийг “өндөр насны тэтгэвэр авагч нас барах үед буюу нас барахаас өмнө нь түүний эхнэр, эсхүл нөхөр нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх” гэсэн тусгай шаардлага мэтээр тайлбарлан хэрэглэх нь хуулийн зорилгод нийцэхгүй, хуулиар ийм шаардлага тавигдсан гэж үзэхгүй.

22.Түүнчлэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр захиргааны байгууллагаас гаргасан аливаа зөвлөмж, аргачлал, цаашилбал захиргааны хэм хэмжээний акт нь хуулиар хязгаарлаагүй асуудлыг хязгаарласан, хүний эрх зүйн байдлыг дордуулах зэргээр хууль зөрчсөн бол түүнийг хэрэглэх ёсгүй. Гэвч Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/82 дугаар зөвлөмжийн тухайд хууль зөрчсөн гэх агуулга алга байна. Тодруулбал, зөвлөмжийн 2.6-д Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн агуулгыг “... Тухайн гэр бүлийн хоёр гишүүн хоёулаа нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байх. Өөрөөр хэлбэл хоёр тэтгэвэр авагчийн аль нэг нь хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр тогтоолгосон бол 20 хувийн нэмэгдлийг тооцон олгохгүй.” гэж тайлбарлажээ. Үүнээс үзвэл, хоёр дахь өгүүлбэр нь эхний өгүүлбэрээ

тодруулсан буюу гэр бүлийн хоёр хүн хоёулаа өндөр насны тэтгэврээс өөр тэтгэвр тогтоолгоогүй байх гэдэг агуулгаар тодруулснаас бус нэг нь нас барах үед нөгөө нь бас тэтгэвэрт гарсан байх гэж тайлбарлаагүй байна. Иймд нэхэмжлэгчид нэмэгдүүлсэн тэтгэвр олгохоос татгалзсан хариуцагчийн эс үйлдэхүй хууль бус юм.

23.Гэтэл хоёр шатны шүүх “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан тусгай зохицуулалтад хамрагдахад мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна, мөн зүйлийн 9.3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01/82 дугаар зөвлөмжийн 2.6-д зааснаас үзвэл гэр бүлийн гишүүн болох нөхөр эсхүл эхнэр хоёул өндөр насны тэтгэврээ тогтоолгон, нийгмийн даатгалын сангаас (нэг төрлийн сан) өндөр насны тэтгэвр хамт авдаг нөхцөлийг хангасан тохиолдолд дээрх хуулийн дагуу өндөр насны тэтгэвр авч байсан нас барагчийн тэтгэврийн 20 хувийг түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэвр дээр нэмэгдүүлэн олгохоор байна ...” хэмээн хуулийг буруу тайлбарлан хэрэглэснээс шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй байна.

24.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Энэ хуулийн 9.1-д заасан тэтгэврийн нэмэгдлийн хэмжээ нь нас барсан тэтгэвр авагчийн авч байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцүү байна” гэж заасан тул нэхэмжлэгч Ж.Уугантөр нь эхнэр Ц.Сосорбурамын авч байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл тэтгэвр авах эрхтэй.

25.Гэхдээ нэхэмжлэлийн “нас барсан тэтгэвр авагчийн 20 хувийг буюу 359,501 төгрөгийг олгохыг даалгах” шаардлагын тухайд, Ц.Сосорбурамын авч байсан тэтгэврийн хэмжээ, түүний 20 хувийн тооцоололтой холбоотойгоор хариуцагчийн зүгээс ямар нэгэн тайлбар гаргаж мэтгэлцээгүй, хоёр шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосонтой холбоотойгоор энэ талаар дүгнэлт хийгээгүй байх тул хариуцагч нэхэмжлэгчийн авах ёстой нэмэгдэл тэтгэврийг холбогдох хууль, журамд заасны дагуу тооцож олгох үүрэгтэй.

26.Дээр дурдсан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангах нь зүйтэй гэж үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:



1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 128/ШШ2025/0328 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 221/МА2025/0416 дугаар магадлалыг хүчингүй болгож, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.1.1, 9.1.2-т заасныг баримтлан нэхэмжлэгч Ж.Уугантөрийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, “Нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувийг Ж.Уугантөрд олгохгүй байгаа хариуцагчийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, нас барсан тэтгэвэр авагч Ц.Сосорбурамын авч байсан тэтгэврийн 20 хувийг зохих журмын дагуу тооцож Ж.Уугантөрд олгохыг Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газарт даалгасугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА

ШҮҮГЧИД

М.БАТСУУРЬ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ

Г.БАНЗРАГЧ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0090

Улаанбаатар
хот

“Алтаншогол” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч шүүгч:	Г.Банзрагч
Танхимын тэргүүн:	Д.Мөнхтуяа
Шүүгчид:	М.Батсуурь П.Соёл-Эрдэнэ
Илтгэгч шүүгч:	Ц.Цогт
Нарийн бичгийн дарга:	Б.Энхжаргал

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
05 дугаар сарын 12-ны өдрийн 128/ШШ2025/0343 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07
дугаар сарын 09-ний өдрийн 221/МА2025/0491 дүгээр магадлалтай,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт
шүүгчийн хуралдааны 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 418 дугаар
хэлэлцүүлэх тогтоолтой захиргааны хэргийг нэхэмжлэгчийн өмгөөлөгч
Б.Баярмаа, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Хонгорзул нарыг
оролцуулан, нэхэмжлэгчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан
гомдлыг үндэслэн хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэлийн шаардлага:

1.Хамтран ажиллах гэрээг цуцлах тухай 2023 оны 01 дүгээр сарын
27-ны өдрийн 228, 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1352 дугаар
шийдвэрүүдийг илт хууль бус захиргааны акт болохыг тогтоолгох.



1.2.Хамтран ажиллах ХАГ/2021001 дугаар гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, уг гэрээг үргэлжлүүлэн алдагдсан цаг хугацааг нөхөж, ажиллуулахыг даалгуулах.

Хэргийн нөхцөл байдал:

2.Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа “Алтан шогол” ХХК-тай Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд байрлах Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн Будда бурханы суурийн музейн барилгыг засах, ашиглалт оруулах, цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ХАГ/2021001, Богдхан уулын дархан цаазат газрын Зайсан-Дугуй цагаан чиглэлийн явган аялагчдад зориулсан авто зогсоол, ариун цэврийн байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ХАГ/2021002 дугаар хамтран ажиллах гэрээг 5 жилийн хугацаатай байгуулжээ.

2.1.Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Мэдэгдэл хүргүүлэх тухай” 228 дугаар албан бичгээр “Алтаншогол” ХХК-д ... гэрээний 9.2, 9.4 дэх заалтыг үндэслэн ХАГ/2021001, ХАГ/2021002 дугаартай хамтран ажиллах гэрээг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн цуцалж байгаа талаар мэдэгджээ.

2.2.Мөн тус захиргаанаас 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Мэдэгдэл хүргүүлэх тухай” 01/1352 дугаар албан бичгээр танай байгууллага тус гэрээний дагуу оруулсан хөрөнгө оруулалт, тохижилтод гаргасан зардлаа нөхөж олсон, ашигтай ажилласан нь санхүүгийн баримтаар нотлогдож байх тул хөрөнгө оруулалтын зардлыг өгөх боломжгүй талаар мэдэгдэл хүргүүлсэн байна.

3.Нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “... Манай компани ямар нэгэн зөрчил гаргаагүй, хамтран ажиллах гэрээний үүргээ зохих ёсоор хангалттай сайн биелүүлж ирсэн. Ямар ч санал авалгүй уг шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэрийг гаргахын өмнө хариуцагчаас талуудын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээг зохих ёсоор дүгнэлгүй, сонсох ажиллагаа хийгээгүй, оруулсан хөрөнгө оруулалт зардлаа хэрхэн нөхсөн талаар ямар нэгэн тооцоо хийгээгүй ... гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, хууль бус шийдвэр гаргасан” гэж,

4.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч буй татгалзлын үндэслэлээ “... 228 болон 01/152 дугаар албан бичиг нь ХАГ/2021001 дугаар гэрээний 9.2, 9.4 дэх хэсэгт заасны дагуу гарсан тул илт хууль бус захиргааны акт биш. ... Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 711 дүгээр тогтоолын 2.4 дэх хэсэгт Бурхан багшийн

цэцэрлэгт хүрээлэнгийн газрын авто зам, зогсоолын талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгчийг зохих хууль, тогтоомжийн хүрээнд дахин сонгон шалгаруулахыг үүрэг болгосон. ... Сонгон шалгаруулалтаар “Наро банчэн худат” НҮТББ сонгогдон гэрээ байгуулсан тул ХАГ/2021001 дугаар гэрээний үүргийн биелэлтийг үргэлжлүүлэн хангуулах боломжгүй” гэж маргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

5.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 128/ШШ2025/0343 дугаар шийдвэрээр: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, 11-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Алтаншогол” ХХК-аас Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд холбогдуулан гаргасан “2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн ХАГ/2021001, ХАГ/2021002 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус цуцлах тухай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 болон 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1352 дугаар шийдвэрүүдийг илт хууль бус захиргааны акт болохыг тогтоолгох, ХАГ/2021001 дугаар гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, уг гэрээг үргэлжлүүлэн алдагдсан цаг хугацааг нөхөж, ажиллуулахыг даалгах” нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

6.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 221/МА2025/0491 дүгээр магадлалаар: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 128/ШШ2025/0343 дугаар шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, 11-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Алтаншогол” ХХК-аас Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд холбогдуулан гаргасан “2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн ХАГ/2021001, ХАГ/2021002 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус цуцлах тухай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 болон 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1352 тоот шийдвэрүүдийг илт хууль бус захиргааны акт болохыг тогтоолгох шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай” гэж, 2 дахь заалтыг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасныг баримтлан ХАГ/2021001 дугаар гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, уг гэрээг үргэлжлүүлэн алдагдсан цаг хугацааг нөхөж, ажиллуулахыг даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчилж, 2 дахь заалтыг 3 дахь заалт болгож, тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээсэн байна.



Хяналтын журмаар гаргасан гомдол:

7.Нэхэмжлэгчийн төлөөлөгч шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ.

7.1.2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1352 дугаар мэдэгдлийг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д зааснаар гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй. Энэхүү мэдэгдлийг гаргахдаа хариуцагч Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.5-д заасан үйл ажиллагааны зарчмыг баримтлаагүй, үндэслэл бүхий байгаагүй. Бид Захиргааны ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д зааснаар оролцогч мөн бөгөөд бидний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргах болсон тухайгаа урьдчилан мэдэгдээгүй, бидний оролцоог хангаагүй. Эрх бүхий байгууллагаас удаа, дараа хяналт шалгалт явагдаж дүгнэлт, зөвлөмж гарсан тухайгаа мэдэгдээгүй, тэдгээр хяналт шалгалтын дүгнэлтэд тайлбар өгөх, няцаалт хийх боломжийг хязгаарлаж хуулиар олгосон эрхийг эдлүүлээгүй. Мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан сонсох ажиллагаа явуулаагүй.

7.2.Манай компани гэрээ байгуулахдаа анх зохих хууль, дүрэм, журмын дагуу тендерт оролцсон ба хариуцагч талд түүнтэй холбоотой баримтууд байхгүй, үрэгдүүлсэн, алга болгосон нь нэхэмжлэгчийн буруутай үйлдэл биш юм. Хяналт шалгалт ороход байхгүй бол манайд хэлээд илүү хувийг авч болох байсан. Хяналт шалгалтын дүгнэлт хэсэгт манай компанийг тодруулан, тодорхой байдлаар буруутгасан агуулга байхгүй. Хэрэв давуу байдал бий болгосон гэж үзэх тохиолдолд холбогдох газраар шалгуулах боломжтой байсан. Бид тендерт оролцоход бүрдүүлж байсан баримтуудыг бусад баримтуудын хамт гаргаж өгсөн боловч шүүх тэдгээрийг нотлох баримтаар үнэлээгүй.

7.3.Анхан шатны шүүхээс хариуцагчийн санхүүгийн тайланд дээд байгууллагаас нь дотоод хяналт шалгалт мөн аудит хийсэн нь тухайн байгууллагын дотоод асуудал байх ба нэхэмжлэгчид огт хамааралгүй байхад төрийн байгууллагаас ирүүлсэн баримтуудыг нэг талыг барьж шийдвэрийн үндэслэх хэсэгт дурдсан ч тэдгээрт хууль зүйн дүгнэлтийг хийгээгүй байгаа юм. Нэхэмжлэгч бид “Наро банчэн хутагт” НҮТББ-ыг эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй, гуравдагч этгээдээр оролцуулах хүсэлт тавьсан боловч шүүх шийдвэрийнхээ 13 дахь хэсэгт ... бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцуулах талаар шийдвэр гаргаагүй гэсэн нь үндэслэлгүй юм.

7.4.Магадлалын хянавал хэсэгт “... аудитын дүгнэлтээр “Алтаншогол” ХХК-д давуу байдал олгосон байж болзошгүй” гэж хэргийн жинхэнэ нөхцөл байдалд тохирохгүй буюу байхгүй үйл баримтад дүгнэлт

хийж байгаад маш их гомдолтой байна. Энэ дүгнэлтээр бусдад давуу байдал олгосон байж болзошгүй байх тул үүнийгээ Авлигатай тэмцэх газарт шалгуулах гэж зөвлөсөн байхад огт шалгуулаагүй байж нэхэмжлэгчийг буруутгасан нь үндэслэлгүй юм.

7.5. Мөн магадлалын 2 дахь заалтад давуу байдал олгосон үйл баримт тогтоогдсон мэтээр, 4.1 дэх заалтаараа нэхэмжлэгч оруулсан хөрөнгө оруулалтыг нөхөж олсон мэтээр, давж заалдах гомдолд дурдсан хууль хэрэглээг няцааж байгаа мэтээр, 5.2 дахь хэсэгт сонгон шалгаруулалтын материалыг хариуцагч хяналт шалгалтынханд өгөөгүйг, мөн хэрхэн шалгаруулсан талаарх баримт байхгүйг зөвтгөж, харин нэхэмжлэгч шүүхэд гаргаж өгсөн тендерийн материалуудыг огт байгаагүй мэтээр, Авлигатай тэмцэх газраас давуу байдал олгосон эсэхийг шалгаагүй байхад шүүх давуу байдал бий болгож шалгаруулсан нь тогтоогдож байна гэж тус тус нотлох баримтгүйгээр шууд дүгнэсэн нь хэргийн бодит байдалтай нийцээгүй. Өөрөөр хэлбэл хэрэгт авагдсан баримтаар нэхэмжлэгч талд хариуцагч нь давуу байдал бий болгож, гэрээ байгуулсан үйл баримт тогтоогдоогүй юм.

Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

8. Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 418 дугаар тогтоолоор нэхэмжлэгчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.2-т заасан үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

ХЯНАВАЛ:

9. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэв.

Тогтоогдсон үйл баримтын тухайд:

10. 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Алтаншогол” ХХК болон Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд байрлах Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн Будда бурхны суурийн музейн барилгыг засах ашиглалтад оруулах, цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилго бүхий ХАГ/2021001 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан. Мөн өдөр “Алтаншогол” ХХК болон Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа Богдхан уулын дархан цаазат



газрын Зайсан-Дугуй цагаан чиглэлийн явган аялагчдад зориулсан авто зогсоол, ариун цэврийн байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилго бүхий ХАГ/2021002 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулжээ.

11.Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 дугаар “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгээр “2022 оны Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүгнэлт болох Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын зөрчил, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зөрчсөн үйлдлийг арилгахыг үүрэг болгосон хэсэг, авто зогсоол, ариун цэврийн байгууламжийг бусдад шилжүүлсэн” гэж тус тус дурдаж, гэрээний 9.2, 9.4 дэх заалтыг үндэслэн ХАГ/2021001 болон ХАГ/2021002 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г цуцалж байгаа талаар мэдэгджээ.

12.Үүний дараа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1352 дугаар “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгээр “дээрх 228 дугаар албан бичигт дурдсан үндэслэлээр гэрээг хоёр талын зөвшилцсөнөөр цуцлахаар тохиролцсон, хөрөнгө оруулалтын зардлыг өгөх боломжгүй” гэж мэдэгдсэн байна.

Энэхүү хэргийн хувьд хяналтын шатны шүүхээс хариу өгөх шаардлагатай хууль зүйн асуудал нь:

-Захиргааны гэрээг цуцалсан захиргааны байгууллагын мэдэгдэл бие даасан захиргааны актад хамаарах эсэх,

-Захиргааны гэрээг цуцлах үндэслэл бүрдсэн эсэх тухай байна.

Хууль хэрэглээний хувьд:

13.Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно” гэж, мөн зүйлийн 52.2-т “Дараах харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно” гээд 52.2.1-д “төрийн алба, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон бусад захиргааны эрх зүйн харилцаанд”, 52.2.2-т “захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд”, 52.2.3-т “төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөөр хэрэгжүүлэхээс бусад дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцаанд”, 52.2.5-д “хуульд заасан бусад харилцаанд” гэж захиргааны гэрээг байгуулж болох харилцааг заажээ.

14.Талуудын хооронд төрийн өмчийг засах ашиглалтад оруулах, цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, явган аялагчдад зориулсан авто зогсоол, ариун цэврийн байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгуулсан хамтран ажиллах гэрээнүүд нь агуулгын хувьд Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.3-т заасан "... дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцаанд" хамаарахаар байна.

15.Мөн хариуцагч Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь уг гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үндэслэн байгуулсан, уг хуулийн 27 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно" гэж заасан байх тул энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.5-д заасан "хуульд заасан бусад харилцаанд" гэдэгт ч хамаарч болохоор байна.

16.Иймээс "Алтаншогол" ХХК болон хамгаалалтын захиргааны хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнүүд нь дээрх Захиргааны ерөнхий хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдах, нийтийн эрх зүйн хүрээнд байгуулагдсан захиргааны гэрээ болно.

17.Зарчмын хувьд захиргааны гэрээний нэг тал болох захиргааны байгууллага нь тухайн гэрээнд заасан үндэслэлээр, эсхүл Захиргааны ерөнхий хуулийн 56 дугаар зүйл юм уу тухайн харилцааг тусгайлан зохицуулсан бусад (нийтийн эрх зүйн) хуульд заасан үндэслэлийн дагуу цуцлах эрхтэй. Харин уг эрхийнхээ хүрээнд гэрээний харилцааг дуусгавар болгохоо илэрхийлж буй захиргааны шийдвэр буюу мэдэгдэл нь захиргааны бие даасан акт болохгүй. Өөрөөр хэлбэл, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан захиргааны актын үндсэн шинжийг агуулахгүй юм. Учир нь, нэгэнт захиргаа бусад этгээдтэй гэрээ байгуулсан бол уг гэрээний харилцааг хуульд заасан үндэслэл үүсээгүй байхад нэг талын "захирамжилсан" шийдвэрээр дуусгавар болгох боломжгүй юм.

18.Иймд маргаан бүхий мэдэгдлүүд нь захиргааны актын шинжийг агуулахгүй тул "Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 дугаар болон 01/1352 дугаар албан бичгүүдийг илт хууль бус захиргааны акт болохыг тогтоолгох" нэхэмжлэлийн шаардлагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д "захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус" гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэв.



19.Анхан болон давж заалдах шатны шүүх дээрх албан бичгүүд нь маргаан бүхий гэрээнээс тусдаа захиргааны акт мөн эсэх талаар дүгнэлт өгөлгүйгээр нэхэмжлэлийн шаардлагыг хянан шийдвэрлэсэн нь буруу байна.

20.Цаашилбал, давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн "... ХАГ/2021001 дугаар гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, уг гэрээг үргэлжлүүлэн алдагдсан цаг хугацааг нөхөж, ажиллуулахыг даалгах" шаардлагыг "тодорхой бус, ойлгомжгүй, бодит байдалд биелэгдэх боломжгүй" гэж дүгнэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасны дагуу захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчилд хамаарна.

21.Учир нь, нэхэмжлэгчийн хүсэл зориг буюу нэхэмжлэлийн шаардлагын агуулга¹ нь ХАГ/2021001 дугаар гэрээний харилцааг үргэлжлүүлэх, хариуцагчаас гэрээний үүргээ биелүүлэхийг шаардаж байх тул энэ тохиолдолд шүүх уг маргааныг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.3-т заасан "нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох" нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэх боломжтой.

22.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.3-т "нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэхийг" гэж, 106 дугаар зүйлийн 106.3.5-д "эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож, хүлээн зөвшөөрөх" гэж тус тус заасан. Улсын дээд шүүхийн 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай" 30 дугаар тогтоолоор тус нэхэмжлэлийн шаардлагыг "нэхэмжлэгч болон бусад оролцогч (хариуцагч, гуравдагч этгээд гэх мэт)-ийн хооронд, эсхүл тодорхой эд юмсын хувьд нийтийн эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр тодорхой эрх зүйн үр дагавар үүссэн эсэхийг буюу эрх, үүрэг байгаа, эсхүл байхгүйг тогтооход чиглэгдсэн нэхэмжлэлийн шаардлага гэж ойлгоно. ... Нийтийн эрх зүйн харилцааг тогтоолгох нэхэмжлэлийг нэгдүгээрт, хүн, хуулийн этгээдийн зүгээс нэхэмжлэлийн бусад үндсэн төрлүүдийг (хүчингүй болгох, даалгах) гаргах боломжгүй, гаргасан ч ижил үр дүнд хүрэхээргүй байх тохиолдолд" гэж тайлбарласан.

23.Нэхэмжлэгчийн хувьд захиргааны актад хамаарах "хүчингүй болгох", "даалгах" нэхэмжлэлийн шаардлагаар өөрийн хүссэн үр дүнд

¹ Улсын дээд шүүхийн тайлбарын эмхэтгэл, *Хууль хэрэглээний нэгдмэл байдал*, 2024, тогтоол №30 х.200

хүрэх боломжгүй байгаа энэ тохиолдолд түүний гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хариуцагчийн хамтран ажиллах гэрээг цуцалсан мэдэгдэл нь талуудын хооронд байгуулагдсан гэрээний нөхцөл, Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хуульд заасан гэрээ цуцлах үндэслэлд хамаарч буй эсэхийг шалгаж тогтоосноор талуудын хооронд нийтийн эрх зүйн буюу захиргааны гэрээний харилцаа үргэлжлэх эсэх, хариуцагч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үндэслэлтэй эсэхийг тогтоох нь зүйтэй.

24. Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 дугаар албан бичигт “гэрээний 9.2, 9.4 дэх заалтыг үндэслэн ХАГ/2021001 болон ХАГ/2021002 дугаар гэрээг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн цуцалж” байгаа талаар мэдэгдсэн. Эдгээр гэрээний 9 дүгээр зүйлд “Гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл”-ийг зохицуулсан ба 9.2-т “Эрх бүхий байгууллагаас тухайн эд хөрөнгийг өөр байгууллагад шилжүүлэх, хувьчлах шийдвэр гаргах” гэж, 9.4-т “Гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл бүрдвэл А тал нь Б талд ажлын 14-өөс доошгүй хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ” гэж тус тус заажээ. Түүнчлэн, гэрээний 9.3-т “Компани гэрээний үүргээ дараах байдлаар зөрчих: а/ “Эд хөрөнгийн төлөвлөлт, зориулалтыг хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр дур мэдэн өөрчлөх”, б “Хариуцагч ашиглаж буй эд хөрөнгийг эвдэж гэмтээх, хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр бусдад түрээслүүлэх, шилжүүлэх болон барьцаалах” гэсэн байна. Гэвч тухайн тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болох эдгээр үндэслэлийн аль нь ч бодит байдалд тогтоогдсонгүй.

25. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 56 дугаар зүйлд захиргааны гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах тусгай тохиолдлыг зохицуулсан бөгөөд 56.1-д “Захиргааны гэрээний агуулгын голлох ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй гэж үзсэн бол уг гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй”, 56.2-т “Өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл захиргааны гэрээг цуцална”, 56.3-т “Захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхолд ноцтой хор уршиг учруулахаар бол түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл арилгах үүднээс захиргааны гэрээг дангаар цуцалж болно” гэж тус тус заасан. Гэвч уг маргааны хувьд хуулийн эдгээр үндэслэл бүрдээгүй байна.

26. Иймд шүүх бүрэлдэхүүн нэхэмжлэлийн “ХАГ/2021001 дугаар гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, уг гэрээг үргэлжлүүлэн алдагдсан цаг хугацааг нөхөж, ажиллуулахыг даалгах” шаардлагыг талуудын хооронд тухайн гэрээний харилцаа байгаа болохыг тогтоож, хариуцагч гэрээний үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй болохыг тогтоох агуулгаар хангаж шийдвэрлэв.



27.Энэхүү шүүхийн тогтоолыг биелүүлэх арга журам, үүсэх үр дагаврын тухайд: Хариуцагчийн зүгээс ХАГ/2021001 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-ний 6.1-д заасан 5 жилийн хугацааг “уг гэрээг цуцлах тухай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 дугаар мэдэгдэл” өгсөн огноогоор түдгэлзүүлж, энэхүү шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон хугацаанаас хойш үргэлжлүүлэн тооцож ажиллах, эсхүл харилцан тохиролцсоны үндсэн дээр цуцлах тохиолдолд гэрээний 9.5-д заасан арга хэмжээг авах үүрэгтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны 128/ШШ2025/0343 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 221/МА2025/0491 дүгээр магадлалыг хүчингүй болгож, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Алтаншогол” ХХК-ийн “Богдхан-Уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн ХАГ/2021001 болон ХАГ/2021002 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-г тус тус цуцлах тухай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 228 болон 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1352 дугаар шийдвэрүүдийг илт хууль бус захиргааны акт болохыг тогтоолгох” нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзсугай.

2.Захиргааны ерөнхий хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 56.3-т заасныг баримтлан нэхэмжлэгч “Алтаншогол” ХХК болон Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны хооронд байгуулагдсан 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн ХАГ/2021001 дугаар “Хамтран ажиллах гэрээ”-ний харилцаа хүчинтэй байгаа болохыг тогтоож, хариуцагч гэрээний үүргийн биелэлтийг хангаж, уг гэрээг үргэлжлүүлэн алдагдсан цаг хугацааг нөхөн тооцож, ажиллах үүрэгтэй болохыг тогтоосугай.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасныг баримтлан нэхэмжлэгчээс хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА

ШҮҮГЧИД

М.БАТСУУРЬ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ

Ц.ЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 001/ХТ2025/0098

Улаанбаатар
хот

“Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч: П.Соёл-Эрдэнэ

Шүүгчид: Г.Банзрагч

Д.Батбаатар

Ц.Цогт

Илтгэгч: Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

Нарийн бичгийн дарга: Б.Энхжаргал

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
07 дугаар сарын 29-ний өдрийн 128/ШШ2025/0532 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 09
дүгээр сарын 17-ны өдрийн 221/МА2025/0602 дугаар магадлалтай,

Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025
оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 001/ШХТ2025/0472 дугаар хэлэлцүүлэх
тогтоолтой хэргийг, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлоор,
нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Ичинхорлоо, нэхэмжлэгчийн
өмгөөлөгч Б.Оюу, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Дуламсүрэн,
Д.Цэцэнхүү нарыг оролцуулан хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага: “Татварын хөнгөлөлт эдлүүлэхээс
татгалзаж шийдвэрлэсэн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2025
оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 4/1900 дугаар шийдвэрийг хүчингүй
болгуулж, татварын хөнгөлөлтөд хамруулахыг Баянзүрх дүүргийн
Татварын хэлтэст даалгах”.

2.Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл:

2.1.“... иргэн Э.Билгүүн нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК болон “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн хувьцаа эзэмшигч тул “Өмгөөллийн авалон лекс” ХХК болон “Уан партнерс ҮЦК” ХХК нь харилцан хамааралтай этгээд гэж дүгнэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Учир нь эдгээр компанийн хөрөнгө болон удирдлага зэрэг бүхий л хүрээнд тусдаа, бие даасан хуулийн этгээдүүд юм. Мөн Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дээр үндэслэн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн удирдлага, хувьцаа эзэмшигчээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй аливаа этгээд оролцох нь хууль зүйн хувьд боломжгүй.

2.2.Өмгөөллийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, 19.6-д заасны дагуу манай компанийн хувьцаа, хувь оролцоог аливаа байдлаар “Уан партнерс ҮЦК” ХХК эзэмшдэггүй бөгөөд хяналт, удирдлагад шууд болон шууд бусаар оролцдоггүй, хуулийн дагуу оролцох боломжгүй. Компанийн зүгээс ийнхүү үүсгэн байгуулагдаад нэг жил болоогүй аж ахуйн нэгж тул хуульд заасан татварын хөнгөлөлтийг эдлэхээр хүсэлт гаргахад түүний зөвхөн нэг хувьцаа эзэмшигчийн өөр тусдаа компанид эзэмшдэг хувьцааг үндэслэн харилцан хамааралтай гэж шууд хамаатуулж, татварын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзсан нь татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна.

2.3. ... Компанийн бусад хоёр хувьцаа эзэмшигчийн хувьд ч хуульд нийцсэн байх, үндэслэл бүхий байх зарчмыг зөрчсөн шударга бус үйл ажиллагаа болсон” гэх агуулгаар маргажээ.

3.Хариуцагчийн хариу тайлбар:

3.1.“... Баянзүрх дүүргийн Татварын хэлтсээс “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг хүлээн авч баталгаажуулан, Татварын ерөнхий газрын Орлогын хяналт, буцаан олголтын хэлтэст хүргүүлсэн. Татварын ерөнхийн газрын Орлогын хяналт, буцаан олголтын хэлтсээс 13 татвар төлөгчийн буцаан олголтын гүйлгээг хянаж, өмнө нь баталсан тушаалд өөрчлөлт оруулах талаар мэдэгдсэн.

3.2.“Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн тайланг ямар шалтгааны улмаас буцаасан талаар Татварын ерөнхий газрын Орлогын хяналт, буцаан олголтын хэлтсээс тодруулахад тус компанийн үүсгэн байгуулагч, 40 хувийн хувьцаа эзэмшигч Э.Билгүүн нь Хан-Уул дүүргийн Татварын хэлтэст бүртгэлтэй “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд 50 хувийн хувьцаа эзэмшдэг байна. “Уан партнерс ҮЦК” ХХК нь 2024 оны



Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайландаа 10 тэрбум гаруй төгрөгийн борлуулалтын орлоготой гэж тусгасан тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасанд хамрагдах боломжгүй тухай хэлсэн.

3.3.Иймд байгууллага болон харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох нийт байгуулалтын орлогын дүн 1.5 тэрбум төгрөгөөс давсан тул хамрагдах боломжгүй” гэх агуулгатай тайлбарыг шүүхэд гаргасан байна.

4.Хэргийн нөхцөл байдал:

4.1.“Өмгөөллийн авалон лекс” ХХК нь 2024 оны Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын жилийн эцсийн тайландаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу ногдуулсан албан татвараас 90 хувиар хөнгөлөлт эдлэх тухай хүсэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр татварын цахим системээр гаргасны дагуу Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр www.etax.mta.mn татварын цахим системд татварын тайланг шалгаж улмаар 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр буцаан олголтыг зөвшөөрчээ.

4.2.Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн даргын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Буцаан олголт авах татвар төлөгчдийн жагсаалт батлах тухай” А/13 дугаар тушаалын хавсралт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны тайлангаар буцаан олголт авах аж ахуйн нэгжийн жагсаалтын 774-т “Өмгөөллийн авалон лекс” ХХК бичигдсэн, уг тушаал, хавсралтыг Татварын ерөнхий газрын Орлогын хяналт, буцаан олголтын хэлтэст хүргүүлсэн байна.

4.3.Татварын ерөнхий газрын Орлогын хяналт, буцаан олголтын хэлтсээс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр “... Танай албаны баталгаажуулсан тушаалаас 13 татвар төлөгчийн буцаан олголтын гүйлгээг хянах шаардлагатай. Хянах шаардлагатай татвар төлөгчдөд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн, өмнөх батлагдсан тушаалд өөрчлөлт оруулах бол буцаан олголтод өөрчлөлт оруулах тухай нэмэлт тушаал гарган тайлбарын хамт ирүүлэх”-ийг мэдэгдсэн.

4.4.Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/22 дугаар тушаалаар буцаан олголт авах аж ахуйн нэгжийн жагсаалтаас “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийг хассан, үндэслэлээ “... танай байгууллага болон харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох нийт байгуулалтын орлогын дүн 1.5 тэрбум

төгрөгөөс давсан тул хамрагдах боломжгүй” гэжээ. Улмаар нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-аас 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 25/99 дүгээр албан бичгээр Татварын ерөнхий газарт хандсан, Татварын ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 05/1253 дугаар албан бичгээр “... Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу танай байгууллагын гүйцэтгэх захирал Э.Билгүүн нь “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг эзэмшдэг бөгөөд тухайн татварын жилд “Өмгөөллийн авалон лекс” нь “Уан партнерс ҮЦК” ХХК-тай ажил гүйлгээ хийсэн, албан татвар ногдох нийт борлуулалтын орлогын нийлбэр 1.5 тэрбум төгрөгөөс давсан тул хөнгөлөлтөд хамрагдах боломжгүй” гэх хариу өгсөн байна.

5.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр:

5.1.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.7, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 27.3, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3 дахь хэсэгт тус тус заасныг баримтлан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ дараах агуулгатай дүгнэлтүүдийг хийсэн байна.

5.1.1.“... Баянзүрх дүүргийн Татварын хэлтсээс 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 4/1900 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичгээр өгсөн хариу нь захиргааны акт мөн. Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Татварын ерөнхий хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.1.2, 81.2-т зааснаас үзэхэд захиргааны актын шинжийг агуулж байна.

5.1.2.Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3-т тус тус заасан нэхэмжлэгч компанийн хувьцаа эзэмшигч Э.Билгүүн нь “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн хувьцаа эзэмшигч байна. Э.Билгүүн нь нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 40 хувийн, “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг эзэмшиж байгаа нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой гэж үзнэ.

5.1.3.“Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн болон “Уан партнерс ҮЦК” ХХК нар хоорондоо ажил гүйлгээ хийсэн бөгөөд хамаарал бүхий этгээдүүд болох нь хэрэгт авагдсан баримтаар нотлогдож байна. “Өмгөөллийн авалон лекс” ХХК-аас 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 09 цаг 54 минут 27 секундэд 4,671,896.22 төгрөгийн гүйлгээг “Уан партнерс ҮЦК” ХХК-д шилжүүлжээ. Мөн “Уан партнерс ҮЦК” ХХК-аас 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 14 цаг 24 минут 18 секундэд “Өмгөөллийн авалон лекс” ХХК-д 34,491,580 төгрөгийн гүйлгээг



тус тус хийсэн байх тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу албан татвар ногдох орлогын дүнг тухайн албан татвар төлөгч болон тухайн татварын жилд түүнтэй ажил гүйлгээ хийсэн харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тооцно.

5.1.4. “Өмгөөллийн авалон лекс” ХХК нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д заасны дагуу татварын тайлангаа илгээхдээ хамаарал бүхий этгээдийн тайланг хамтад нь илгээх нь нэхэмжлэгч компанийн үүрэг тул энэ талаарх нэхэмжлэгчийн тайлбар үндэслэлгүй.

5.1.5. Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/22 дугаар тушаал хүчинтэй хэвээр байгаа, энэ талаар маргаагүй, нэхэмжлэлийн шаардлага гаргаагүй болохыг дурдах нь зүйтэй” гэжээ.

6. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал:

6.1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийсэн:

6.1.1. “... Э.Билгүүн нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 40 хувийн хувьцаа, “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг тус тус эзэмшдэг нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар тогтоогдож байх бөгөөд Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3-т заасны дагуу дээрх хоёр хуулийн этгээдийг харилцан хамаарал бүхий этгээд гэж үзнэ.

6.1.2. ... Харилцан хамаарал бүхий этгээдүүд болох “Уан партнерс ҮЦК” болон “Өмгөөллийн авалон лекс” ХХК нар хоорондоо 2024 онд ажил гүйлгээ хийсэн, уг этгээдүүдийн тухайн татварын жилд албан татвар ногдох орлогын нийлбэр дүн 1,5 тэрбум төгрөгөөс илүү байгаа энэ тохиолдолд хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзэхгүй бөгөөд “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн албан татварыг 90 хувиар хөнгөлөх хууль зүйн үндэслэлгүй.

6.1.3. Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 38 дугаар зүйлийн 38.4-т заасны дагуу “Уан партнерс ҮЦК” болон “Өмгөөллийн авалон лекс” ХХК нар нь харилцан хамаарал бүхий этгээд байх энэ тохиолдолд “... мэдээлэл шууд автоматаар гарч ирсэн ба тус мэдээллийг хасах, засах боломжгүйгээр заавал илгээхээр гарч ирсэн ...” гэх нэхэмжлэгчийн тайлбар үндэслэлгүй” гэжээ.

7.Хяналтын журмаар гаргасан гомдлын агуулга:

7.1.Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Ичинхорлоогоос 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хяналтын журмаар гаргасан гомдолдоо: “... Анхан шатны шүүхээс Э.Билгүүн нь нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 40 хувийн, “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг эзэмшиж байгаа нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой гэж үзнэ” гэж дүгнэснийг давж заалдах шатны шүүхээс “Э.Билгүүн нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 40 хувийн хувьцаа, “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг тус тус эзэмшдэг нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар тогтоогдож байх бөгөөд Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3-д заасны дагуу дээрх хоёр хуулийн этгээдийг харилцан хамаарал бүхий этгээд гэж үзнэ” гэж зөвтгөсөн боловч хуулийг ийнхүү хэрэглэх болсон үндэслэлээ огт тайлбарлаагүй нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчмыг хангахгүй гэж үзэж байна.

7.1.1.Учир нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ”, 27.1.3 дахь хэсэгт “хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд” гэж заасан. Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг задлан авч үзвэл: “Нэг этгээд нь нөгөө этгээдийн” хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой. Энэ тохиолдолд “Өмгөөллийн авалон лекс” ХХК нь “Уан партнерс ҮЦК” ХХК, эсхүл “Уан партнерс ҮЦК” ХХК нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцож буйг ойлгохоор байгаа бөгөөд; “Эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдүүдийн” хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой. Энэ тохиолдолд “Өмгөөллийн авалон лекс” ХХК болон “Уан партнерс ҮЦК” ХХК-ууд нь өөр 2 болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцож буйг ойлгохоор байна.

7.1.2.Гэвч Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3 дахь заалтууд нь нэг нэгнийхээ хувьцааг эзэмшдэг /шууд/ болон



гинжин хэлхээний дундах /шууд бус/ компаниудыг хамааруулан авч үзэх агуулгатай байна. Иймд хуулийг нэг иргэний 2 өөр компанид эзэмшдэг хувь эзэмшлээр нь тухайн компаниудыг харилцан хамааралтай гэж холбож үзэх нь хууль зүйн хувьд үндэслэлгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэж хуулиар олгосон үндсэн эрхийг хязгаарлаж байна.

7.1.3. Мөн “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн хувьд Өмгөөллийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, 19.6-д тус тус заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигч, удирдлага нь өмгөөлөгч бус этгээд байх нь хориотой. Харин нөгөө талаас “Уан партнерс ҮЦК” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ТЗ 309/15 дугаар тусгай зөвшөөрөл авсан ба энэ нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д “хөрөнгө оруулалтын менежментийн компани гэж хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалтай хуулийн этгээдийг” гэж заасны дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.

7.1.4. Иймд хөрөнгө оруулалтын менежмент, бизнесийн чиглэлээр зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлдэг нэг аж ахуйн нэгж нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын хөрөнгийн өмчлөл болоод удирдлага, хяналт, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох боломжгүй, эдийн засгийн нэгдмэл ашиг сонирхолтой байх боломжгүй бөгөөд харилцан хамааралтай гэж үзэх нь учир дутагдалтай.

7.2. Үүнээс гадна шүүхээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т татварын 90 хувийн хөнгөлөлт эдлүүлэх шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо “... албан татвар ногдох орлогын дүнг тухайн албан татвар төлөгч болон тухайн татварын жилд түүнтэй ажил гүйлгээ хийсэн харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тооцно” гэж заасны дагуу нэхэмжлэгч компанийг “Уан партнерс ҮЦК” ХХК-тай “харилцан хамааралтай этгээдүүд” гэж “улсын бүртгэл дэх мэдээллийг үндэслэн” шууд үзсэний дараа “тухайн жилд хоорондоо ажил гүйлгээ хийсэн тул” гэж 2 компанийн орлогын нийлбэр дүнгээр татвар ногдох орлогыг тодорхойлсныг үндэслэлтэй гэж үзсэн. Гэвч харилцан хамааралтай этгээдүүдийн орлогын нийлбэр дүнгээр татварын хөнгөлөлт эдлүүлэх эсэхийг тогтоосон энэхүү заалт нь харилцан хамааралтай этгээд нь өөрөө “жижгэрээд” 90 хувийн хөнгөлөлт эдлэхээр эдийн засгийн үр дүнд нөлөөлөх эрсдэлээс сэргийлэх агуулгатай заалт байсныг тухайн үеийн хууль тогтоогчдын үзэл санаа хуулийн хувийн хэрэг дэх хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгагдсанаас харж болохоор байна. /2-р хавтаст хэргийн 4-р тал/

7.2.1. Гэтэл хуулийн хүрээнд, дээр дурдсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулдаг 2 өөр мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн хувь нийлүүлэгчээр өмгөөлөгчөөс бусад мэргэжлийн этгээд оролцохгүй байх шаардлага, 2 компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөр бусад хамааралгүй этгээдүүд оролцсон байдал зэргээс “Өмгөөллийн авалон лекс” ХХК болон “Уан партнерс ҮЦК” ХХК-ууд нь татвар ногдох орлогоо харилцан хуваах замаар (хуульд зааснаар хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар) 1.5 тэрбум төгрөгөөс бууруулж, хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжгүй гэдэг нь нотлогддог. Хууль тогтоогчийн үзэл санаанаас харвал, жишээлбэл 1.5 тэрбумаас дээш татвар ногдох орлоготой, худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг компани нь өөрийн охин компаниараа дамжуулж зарим үйл ажиллагаагаа шилжүүлж, орлого олох замаар татвар ногдох орлогоо бууруулж тайлагнасны дүнд татварын хөнгөлөлтөд хамрагдахаас сэргийлсэн гэж үзэхээр байна. Гэтэл дээр тайлбарласны дагуу нэхэмжлэгч компанийн хувьд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны орлого олох, удирдлага, хяналтад оролцох, эсвэл хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компани өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, хууль зүйн туслалцаа үзүүлж орлого олох аливаа боломжгүй.

7.2.2. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлахдаа жижиг, дунд үйлдвэрийн тогтвортой хөгжлийг дэмжих эрх зүй, санхүү, татварын таатай орчин бүрдүүлэхийг зорьсон. Үүний дагуу 2019 онд батлагдсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, байдлыг нь харгалзан төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ” гэж заасан. Үүний дагуу жижиг үйлчилгээ эрхлэгчийн хувьд нэхэмжлэгч компани цаашид тогтвортой хөгжихөд татварын дарамтыг багасгуулах, үүгээр төвлөрсөн орлогоор ажилтнуудынхаа цалинг зах зээлийн тогтворгүй, хүндрэлтэй нөхцөлөөс үл хамаарч, урт хугацаанд тасралтгүй олгож, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх нь нэн тэргүүний зорилт юм. Гэвч ийнхүү татварын алба, шүүхээс хуулиар олгогдсон хөнгөлөлт эдлэх энэхүү эрхийг шударга бусаар хязгаарлаж байгааг зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэгт заасны дагуу татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд “шударга байх” зарчмыг баримтлах шаардлагатай.

7.2.3. Ийнхүү хэрэв цаашид шүүхээс Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу “харилцан хамааралтай



этгээд” гэх ойлголтыг хэт хавтгайруулж тайлбарлавал шинээр үүсгэн байгуулагдсан бичил, эсхүл жижиг аж ахуйн нэгж нь аль нэг хөрөнгө оруулагчийн хувийн бөгөөд тухайн аж ахуйн нэгжид огт хамааралгүй эд хөрөнгийн эрхээс хамаарч татварын хөнгөлөлт эдлэх, эдлэхгүй нь шийдэгдэхээр байна. Энэ нь хууль болон Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилттой нийцэхгүй гэж үзэж байна. Хуулийг ийнхүү буруу хэрэглэх нь зөвхөн нэхэмжлэгч компанийн тохиолдлоор хязгаарлагдах биш, бичил, эсхүл жижиг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч аливаа хөрөнгө оруулалт татахдаа хөрөнгө оруулагчийн хувийн байдал, бусад аливаа компанид эзэмшиж буй хувьцааны хэмжээг “урьдчилан шалгаж байж”, хөрөнгө оруулахыг зөвшөөрч байх бодит нөхцөл байдалд нийцэхгүй шаардлагыг тавьж байгаатай ижил бөгөөд ирээдүйд бичил, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтыг хязгаарлах, хумих, эдийн засгийн сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй гэж үзэж байна.

7.2.4.Дээрхээс үзвэл, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан “харилцан хамааралтай этгээд”-ийн тухай ойлголтыг зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс шийдвэрлэх нь ижил төстэй хэргүүдийг цаашид нэг мөр, зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

7.2.5.Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2 дахь хэсэгт “Шүүх хяналтын журмаар хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана” гээд тус зүйлийн 127.2.4-т “шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангах” гэж заасны дагуу нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 128/ШШ2025/0532 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 221/МА2025/0602 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

8.Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 001/ШХТ2025/0472 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

9.Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс хяналтын журмаар гомдол гаргасныг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр цахимаар хүргүүлэв. Хяналтын журмаар гаргасан гомдолд холбогдуулж аливаа тайлбарыг бичгээр гаргаагүй байна.

ХЯНАВАЛ:

10.Хяналтын шатны шүүх дараах үндэслэлээр, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэв.

11.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, ... /ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах; согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох; газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулах-аас бусад салбарт/ үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө” гэж заасны дагуу “Өмгөөллийн авалон лекс” ХХК-аас 2024 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлүүлэх хүсэлтийг татварын албанд гаргажээ.

12.Хариуцагчаас “... “Өмгөөллийн авалон лекс” ХХК болон харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох нийт байгуулалтын орлогын дүн 1.5 тэрбум төгрөгөөс давсан тул хамрагдах боломжгүй” гэх үндэслэлээр татварын хөнгөлөлт эдлүүлэхээс татгалзсан, энэ хэргийн тухайд хяналтын шатны шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох зорилгын хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлэж хариу өгөх нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан “албан татвар ногдох орлого нь тухайн жилд 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байгаа аж ахуйн нэгжид ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлөх”-тэй холбоотой зохицуулалтыг цаашид зөв хэрэглэхэд зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзэв. Үүнд:

12.1.а/ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан “албан татвар ногдох орлого нь тухайн жилд 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байгаа аж ахуйн нэгжид ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлөх” зохицуулалтыг мөн хуулийн 22.3 дахь заалтын “албан татвар ногдох орлогын дүнг тухайн албан татвар төлөгч болон тухайн татварын жилд түүнтэй ажил гүйлгээ хийсэн харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тооцох” зохицуулалттай харилцан уялдаанд нь, хуулийн зохицуулалтын зорилгод нийцүүлэн тайлбарлах, маргааны үйл баримтад холбогдуулан уг заалтыг шүүхүүд зөв хэрэглэсэн эсэх;



12.2.б/ Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ” гэх зохицуулалтын тусгай нөхцөлүүдийг энэ тохиолдолд шүүхүүд маргааны үйл баримтад холбогдуулан зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх;

13.Нэг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3 дахь хэсгийн зохицуулалтуудын харилцан уялдаа холбооны талаар:

13.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт албан татвар ногдох орлого нь тухайн татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байгаа нь жилийн эцсийн татварын тайлангаар тодорхойлогдсон бөгөөд хөнгөлөлт эдлүүлэхгүй байхаар хуульд тусгайлан зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчид тухайн жилд ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр заасан, уг зохицуулалтын зорилго нь жижиг, дунд үйлдвэрлэл, бага, дунд орлоготой аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих явдал бөгөөд энэ зорилгоор нэг жилд 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй орлого олдог аж ахуйн нэгжийг албан татвараас хөнгөлөх, нэг жилд ногдуулсан албан татварыг 90 хувиар багасгах замаар татварын бодлогоор дэмжих зорилготой болох нь хэрэгт авагдсан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэл, хуулийн төслийн үзэл баримтлалаар тогтоогдож байна.

13.2.Харин аж ахуйн нэгжүүд албан татварын хөнгөлөлтөд хамрагдахын тулд орлогын хэмжээгээ багасгах, энэ зорилгоор орлогыг хуваахаас сэргийлж, харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн гүйлгээг хамтад нь хянах шаардлагатай талаар мөн хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаж, хууль тогтоогчоос энэ зорилгоор хуулийн 22.3 дахь заалтыг оруулж буй талаар тодорхой хэлэлцэгдсэн нь мөн хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлд тусгагджээ.

13.3.Эдгээрээс дүгнэвэл, хөнгөлөлт эдлүүлэхгүй байхаар хуульд тусгайлан зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн нэг жилд олсон орлогыг бодитой, объектив шалгуураар тодорхойлж, бодит байдалд 1,5 тэрбум төгрөг хүрээгүй нь тогтоогдож буй тохиолдолд уг аж ахуйн нэгжийг тухайн жилд төлвөл зохих албан татвараас 90 хувь хөнгөлөх нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн уг зохицуулалтад нийцэхээр байна.

13.4.Өөрөөр хэлбэл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т “Энэ хуулийн ... 22.1-д тухайн албан татвар төлөгч хамаарах эсэхийг тодорхойлохдоо албан татвар ногдох орлогын дүнг тухайн албан татвар төлөгч болон тухайн татварын жилд түүнтэй ажил гүйлгээ хийсэн харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тооцно” гэж заасныг хэрэгжүүлэхдээ тухайн албан татвар төлөгч болон түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдүүдийн тухайн татварын жилд хоорондоо хийсэн ажил гүйлгээ нь татварын хөнгөлөлтөд хамрагдахын тулд орлогыг хуваах зорилготой эсэх, уг ажил гүйлгээний үнийн дүн нь аль нэгийг нь хувьд хуулиар тогтоосон 1.5 тэрбум төгрөгийн хязгаарлалтын босго дүнд нөлөөлж буй эсэхийг харгалзан үзэх шаардлагатай гэж хяналтын шатны шүүх үзлээ.

13.5.Хэрэгт авагдсан баримтаар, нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК нь “өмгөөллийн үйл ажиллагаа” эрхэлдэг, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж бөгөөд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар 2024 онд бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын нийт орлого нь 889,730,111 төгрөг буюу 1.5 тэрбум төгрөг хүрээгүй тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу татварын хөнгөлөлт эдлэх суурь болзлыг хангасан байжээ. Түүнчлэн тус компани нь тайлант хугацаанд буюу 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 4,671,896.22 төгрөгийг “Уан партнерс ҮЦК” ХХК-д шилжүүлсэн, бусдад шилжүүлсэн уг 4,7 сая орчим төгрөгийн гүйлгээ нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт заасан татварын хөнгөлөлт эдлүүлэх эсэхийг шийдвэрлэх албан татвар ногдох орлогын босго дүн болох 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан эсэхэд нөлөөлөхгүй байх тул уг гүйлгээг татварын хөнгөлөлтөд хамрагдахын тулд орлогыг хуваах зорилготой гэж үзэхгүй.

13.6.Иймд, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн “татварын хөнгөлөлт эдлүүлэх”-тэй холбоотой уг зохицуулалт нь тодорхой этгээдэд чиглэсэн, тодорхой зорилготой, хэрэгжүүлэх арга замыг хуулиар тусгайлан тогтоосныг харилцан хамаарал, уялдаанд нь тайлбарлан хэрэглэж, энэ тохиолдолд татвар төлөгчид хуулиар тусгайлан олгогдсон эрхийг шүүх хамгаалах нь татварын хөнгөлөлт эдлүүлэхэд тавигдах хязгаарлалтын зорилго, агуулгад нийцнэ.

14.Хоёр. Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “харилцан хамаарал бүхий этгээд”-ийг маргааны үйл баримтад холбогдуулан зөв тодорхойлох талаар:



14.1.Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаар татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим нь “зайлшгүй байх”, “тодорхой байх”, “шударга байх”, “үр ашигтай байх” гэж заасан, аливаа татварын ногдуулалт, төлөлтийн үйл ажиллагаанд хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхэд эргэлзээ, маргаан гарвал эдгээр зарчмуудын агуулгад нийцүүлэн тодорхойлно.

14.2.Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ” гээд 11 тохиолдол буюу хэлбэрийг нэрлэн заажээ.

14.3.Энэ тохиолдолд, иргэн Э.Билгүүн нь нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 40 хувийн, “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг тус тус эзэмшдэг, хэргийн оролцогчид уг үйл баримттай маргаагүй, энэ нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-т “хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд” гэх шалгуурт нийцсэн гэж хариуцагч болон шүүхүүд үзсэн байна.

14.4.Энэ маргааны тухайд, Татварын ерөнхий хуульд заасан “харилцан хамаарал бүхий этгээд”-ийн зохицуулалтыг хэрэглэж буй зорилго нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасан “албан татвар ногдох орлогын дүн”-г тодорхойлох буюу харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн гүйлгээг хянах замаар хуулийн 22.1 дэх хэсэгт заасан татварын хөнгөлөлт эдлүүлэх эсэхийг шийдвэрлэхэд чиглэгдэж байх тул эдгээр зохицуулалтуудыг мөн харилцан хамааралд нь тайлбарлан хэрэглэх шаардлагатай.

14.5.Хэрэгт авагдсан баримтаар, нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК нь 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 4,671,896.22 төгрөгийг “Уан партнерс ҮЦК” ХХК-д шилжүүлсэн, мөн “Уан партнерс ҮЦК” ХХК-аас 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр “Өмгөөллийн авалон лекс” ХХК-д 34,491,580 төгрөгийг шилжүүлсэн, эдгээр харилцан шилжүүлсэн гүйлгээнүүд нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК нь татварын хөнгөлөлтөд хамрагдах шалгуур хангасан эсэхтэй холбоотой энэ маргааны тохиолдолд “Өмгөөллийн авалон лекс” ХХК, “Уан партнерс ҮЦК” ХХК-ууд нь “нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд

бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой” байх хуулийн шалгуур хангаагүй гэж үзлээ.

14.6.Тодруулбал, “Өмгөөллийн авалон лекс” ХХК нь татварын хөнгөлөлтөд хамрагдах эрхтэй эсэх буюу уг компанийн “албан татвар ногдох орлогын дүн”-г тодорхойлох зорилгоор түүний харилцан хамаарал бүхий этгээдийг тодорхойлох шаардлага үүссэн, энэ тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “хоорондоо харилцан хамааралтай этгээд”-үүдийг тодорхойлохдоо “нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой” байх шалгуур тавьсныг маргааны үйл баримтад холбогдуулан тайлбарлахаар байжээ.

14.7.Хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон “Өмгөөллийн авалон лекс” ХХК, “Уан партнерс ҮЦК” ХХК-уудын 2024 онд харилцан хийгдсэн 39 сая орчим төгрөгийн гүйлгээ нь бодит байдалд тус компаниудын хооронд хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар “тусгай нөхцөлөөр ажил гүйлгээ хийж, эдийн засгийн үр дүн үүсгэсэн”, тийм боломжийг харилцан бий болгосон гэж үзэхээргүй, уг гүйлгээний улмаас “Өмгөөллийн авалон лекс” ХХК-нд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт заасан татварын хөнгөлөлт эдлүүлэх эсэхийг шийдвэрлэхэд ямар нэг давуу байдал, үр дагавар үүсгээгүй байна.

14.8.Иргэн Э.Билгүүн нь нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 40 хувийн, “Уан партнерс ҮЦК” ХХК-ийн 50 хувийн хувьцааг тус тус эзэмшдэг, энэ нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-т заасан “хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд” гэх хэлбэрийн шалгуурт нийцэж байх хэдий ч энэ тохиолдолд 27.1 дэх заалт нь “Өмгөөллийн авалон лекс” ХХК-д татварын хөнгөлөлт эдлүүлэхээс татгалзсан шийдвэрийн үндэслэл болсон энэ маргааны тухайд дээрх агуулгаар “харилцан хамаарал бүхий этгээд” байх ерөнхий шалгуурт нийцээгүй гэж үзлээ.

14.9.Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн хуулиар тусгайлан заасан татварын хөнгөлөлт эдлэх эрхийг эдлүүлэхээс татгалзахдаа хариуцагчаас Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг буруу хэрэгжүүлснийг шүүхүүд анхаараагүй, уг заалтын тусгай нөхцөлүүдийг маргаан бүхий энэ тохиолдолд тайлбарлан хэрэглээгүй, хуульд заасан шалгуур хангасан татвар төлөгчийн хөнгөлөлт эдлэх эрхийг эдлүүлэхээс



татгалзаж шийдвэрлэсэн нь Татварын ерөнхий хуульд заасан татвар “тодорхой байх”, “шударга байх” зарчмын агуулгад нийцэхгүй байна.

14.10.Хяналтын шатны шүүхийн энэхүү дүгнэлт нь гагцхүү Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3-т заасан “татвар төлөгчийг тухайн жилд ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлөх”-тэй холбоотой харилцаанд “хоорондоо харилцан хамааралтай этгээд”-ийг тодорхойлоход буюу энэ маргааны тухайд хамааралтай болохыг дурдах нь зүйтэй.

15.Эдгээр үндэслэлээр нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн гаргасан “Татварын хөнгөлөлт эдлүүлэхээс татгалзаж шийдвэрлэсэн Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 4/1900 дугаар шийдвэрийг хүчингүй болгуулж, татварын хөнгөлөлтөд хамруулахыг Баянзүрх дүүргийн татварын хэлтэст даалгах” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэв.

16.Хариуцагч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн татварын тайлангаар тодорхойлон, хуульд заасан хугацаанд төлсөн албан татвараас буцаан олгож, хяналтын шатны шүүхийн энэ шийдвэрийг биелүүлнэ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 128/ШШ2025/0532 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 221/МА2025/0602 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 22.3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Өмгөөллийн авалон лекс” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, татварын хөнгөлөлт эдлүүлэхээс татгалзсан Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 4/1900 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, татварын хөнгөлөлтөд хамруулахыг Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст даалгасугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийг тус тус баримтлан нэхэмжлэгчээс нэхэмжлэл гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн

орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөг гаргуулж нэхэмжлэгчид олгон, нэхэмжлэгчээс хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргах эрхгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА

ШҮҮГЧИД

Г.БАНЗРАГЧ

Д.БАТБААТАР

Ц.ЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 001/ХТ2026/0001

Улаанбаатар
хот

“Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-ийн нэхэмжлэлтэй, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Танхимын тэргүүн: Д.Мөнхтуяа

Шүүгчид: Г.Банзрагч

Д.Батбаатар

Ц.Цогт

Илтгэгч шүүгч: М.Батсуурь

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга: Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
06 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2025/0452 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 09
дүгээр сарын 16-ны өдрийн 221/МА2025/0591 дүгээр магадлалтай,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн
хуралдааны 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 001/ШХТ2025/0526
дугаар хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, нэхэмжлэгчийн төлөөлөгч
Ж.Майзориг (цахимаар), нэхэмжлэгчийн өмгөөлөгч С.Батбуян (№2558),
хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Алтан-Эрдэнэ, М.Ганзул,
Б.Даваагэрэл, Г.Намуунаа, Ч.Октябрь, Ц.Ундармаа нарыг оролцуулан,
нэхэмжлэгчийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан
гомдлоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Нэхэмжлэлийн шаардлага:

1.“Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-өөс Сүхбаатар
дүүргийн Татварын хэлтэст холбогдуулан “Татварын буцаан олголт авахаар

татварын цахим системээр гаргасан хүсэлтийг тус Татварын хэлтсээс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 17:33:39 цагт цуцалсан нь хууль бус болохыг тогтоолгох, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 03/705 дугаар албан бичгийг хүчингүй болгуулж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэгт заасны дагуу 101,878,832.8 төгрөгийн татварын буцаан олголт олгохыг Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст даалгах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Хэргийн нөхцөл байдал:

2.“Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу аж ахуй нэгжийн албан татварын 2024 оны буцаан олголтыг авах тухай хүсэлтийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр www.etax.mta.mn татварын цахим системээр гаргасан ба уг хүсэлтийг хариуцагч Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсээс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр www.etax.mta.mn татварын цахим системд цуцалсан төлөвтэй болгожээ.

3.Цуцалсан төлөвтэй холбогдуулан “Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-өөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн М-25/31 дүгээр албан бичгээр Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн даргад гомдол гаргаж, тус хэлтсээс 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 03/705 дугаар албан бичгээр гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх боломжгүй тухай мэдэгдсэн байна.

4.Дээрх албан бичигт “... татвар ногдуулах орлого гэдэг нь татвар ногдох орлогоос хуулийн дагуу хасагдах зардлыг хасаж ногдуулсан төлбөл зохих албан татварын дүн юм ... Танай байгууллагын албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс их дүнгээр жилийн эцсийн тайланд тусгагдсан байх тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татварын хөнгөлөлт эдлэх боломжгүй” гэж дурджээ.

5.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2025/0452 дугаар шийдвэрээр: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэгт тус тус заасныг баримтлан нэхэмжлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-ийн гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, татварын буцаан олголт авахаар татварын цахим системээр гаргасан хүсэлтийг Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсээс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 17:33:39 цагт цуцалсан нь хууль бус болохыг тогтоож, Аж ахуйн нэгжийн орлогын албан



татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэгт заасны дагуу 101,878,832.8 төгрөгийн татварын буцаан олголтыг нэхэмжлэгчид олгохыг Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст даалгажээ.

6.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 221/МА2025/0591 дугаар магадлалаар: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2025/0452 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 18 дугаар зүйлийн 18.2, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасныг үндэслэн нэхэмжлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-өөс Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст холбогдуулан гаргасан “Татварын буцаан олголт авахаар татварын цахим системээр гаргасан хүсэлтийг Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсээс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 17:33:39 цагт цуцалсан нь хууль бус болохыг тогтоолгох, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэгт заасны дагуу 101,878,832.8 төгрөгийн татварын буцаан олголт олгохыг Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

7.Нэхэмжлэгчийн төлөөлөгч Ж.Майзориг, өмгөөлөгч С.Батбуян нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авч, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 001/ШХТ2025/0526 дугаар хэлэлцүүлэх тогтоолоор “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах”, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх гэсэн үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:

8.Нэхэмжлэгчийн төлөөлөгч Ж.Майзориг, өмгөөлөгч С.Батбуян нараас магадлалыг эс зөвшөөрч хяналтын журмаар дараах (агуулгаар нь тусгав) гомдлыг гаргажээ. Үүнд:

8.1.Нэхэмжлэгчийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан орлого 1.1 тэрбум төгрөг тул татварын хөнгөлөлт авах эрх үүссэн. Харин тухайн жилийн нийт борлуулалтын орлогын дүн 1.9 тэрбум төгрөг бөгөөд энэ нь татварын хөнгөлөлт тооцохтой уялдаа, хамааралтай дүн биш. Анхан шатны шүүх Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 гэсэн зохицуулалтыг системчлэлийн аргаар үндэслэл бүхий тайлбарласан бол; давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн дүгнэлтийг ямар үндэслэлээр буруу гэж үзэж байгаа талаараа

тайлбарлахгүйгээр, татварын хуулийн зохицуулалтыг зөвхөн үгчлэх байдлаар тайлбарлан хэрэглэж, шийдвэрийг хүчингүй болгосон.

8.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “тус хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан” бол хөнгөлөлт үзүүлнэ гэсэн. Хэрэв энд заасан 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй гэдэг нь нийт борлуулалтын орлогыг илэрхийлсэн бол энэ хэсэгт тус хуулийн “18.2-т заасан албан татвар ногдох орлого” гэж тодруулан эшлэхгүй.

8.3. 2018 онд хуулийг сайжруулан, шинэчлэн найруулахдаа 22.1-д “тус хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй” гэсэн нь 2006 оны хуулиас шинэ агуулга, зохицуулалтыг оруулж ирсэн. Хэрэв хариуцагчийн тайлбарлаж байгаа шиг 2006 онд хуульд байсан агуулгыг 2018 онд хуульд хэвээр оруулах байсан бол хууль тогтоогч 18.2 дахь хэсгийг эшилж, тодруулахгүй. Харин 2018 оны хуулийн төслийн анхны хувилбарын 22.1 дэх хэсэг нь аливаа тодруулга заалт, зохицуулалт эшлэхгүйгээр “албан татвар төлөгчийн жилийн татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, дор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө” гэсэн байсан. Эндээс үзэхэд, үзэл баримтлалын дагуу хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулахдаа, энэ хэсэгт дурдсан 1.5 тэрбумын борлуулалтын орлого гэдэг нь ААН-ийн тухайн жилийн нийт борлуулалтын орлогыг илэрхийлж байж. Харин хуулийн төслийг хэлэлцүүлгийн материалаас үзэхэд, 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Төсвийн байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 17, мөн Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төсвийн байнгын хорооны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийн 27 дахь талд ... тус тус өөрчлөн найруулахаар тусгасан нь ... одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 22.1 дэх хэсэгтэй таарч байна.

8.4. Хууль эцэслэн батлагдахад, тус хуулийн 22.1 дэх хэсэг нь “энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан ... албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө” гэж батлагдсан. Иймд анхан шатны шүүхийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэл бүхий байдлаар тайлбарласан.

8.5. Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн зохицуулалт нь татвар



шударга байх зарчим, татвар төлөх төлбөрийн чадварын зарчим, харилцан ашигтай байх зарчим (Wicksell-Lindahl), Хайг-Саймонсийн орлогын онол, орчин үеийн татварын шударга ёсны онолууд, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон Олон улсын валютын сангийн байр суурь, онол зарчмуудад үндэслэж “тус хуулийн 18.2-т заасан буюу зардал хассан татвар ногдуулах орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй бол” хөнгөлөлт эдлүүлэхээр зохицуулсан байна. Иймд магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү гэжээ.

9.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас нэхэмжлэгч талын хяналтын журмаар гаргасан гомдолд холбогдуулж бичгээр тайлбар ирүүлээгүй.

ХЯНАВАЛ:

10.Давж заалдах шатны шүүхийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шийдэл зөв боловч хууль тайлбарлах аргыг бүрэн хэрэглээгүй тул энэ талаар тодруулж, магадлалыг хэвээр үлдээв.

11.Нэхэмжлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-өөс Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэст холбогдуулан “татварын буцаан олгох хүсэлтийг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 17:33:39 цагт цуцалсан нь хууль бус болохыг тогтоолгох, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03/705 дугаар албан бичгийг хүчингүй болгуулж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2-т заасны дагуу 101,878,832.8 төгрөгийн татварын буцаан олголт олгохыг даалгах” нэхэмжлэлийн шаардлага гаргаж, “... манай байгууллагад татварын буцаан олголт авар эрх үүссэн, учир нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т зааснаар албан татвар ногдох борлуулалтын орлогын нийт дүнгээс тус хуульд заасан зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, уг орлогоос энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шилжүүлэн тооцох алдагдал байхгүй буюу “0”-ийг хасаж 2024 оны албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход 1,131,961,844.07 төгрөг гарч байгаа болно” гэж; хариуцагчаас “... татвар ногдуулах орлого гэдэг нь татвар ногдох орлогоос хуулийн дагуу хасагдах зардлыг хасаж ногдуулсан төлбөл зохих албан татварын дүн юм. Танай байгууллагын албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс их дүнгээр жилийн эцсийн тайланд тусгагдсан байх тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан албан татварын хөнгөлөлт эдлэх боломжгүй байна” гэж маргасан бөгөөд анхан болон давж заалдах шатны шүүхүүд энэ хүрээнд холбогдох хуулийн зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэсэн байна.

12. Үүнээс үзэхэд, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “албан татвар ногдох орлого” гэж заасан нь хуульд тусгасан хасагдах зардлыг тооцохоос өмнөх аж ахуйн нэгжийн тухайн жилийн нийт бараа, ажил, үйлчилгээний орлогын дүнг илэрхийлэх, эсхүл аж ахуйн нэгжийн тухайн жилийн нийт бараа, ажил, үйлчилгээний албан татвар ногдох орлогоос мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан хасагдах зардлыг хасаж тооцсоны дараах орлогыг илэрхийлэх эсэх нь маргааны гол зүйл болжээ.

13. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Энэ хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 9.1.1, 11.1.1, 11.1.4-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс энэ хуульд заасан зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, уг орлогоос энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шилжүүлэн тооцох алдагдлыг хасаж тухайн жилийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно”, 18.3-т “Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсэн үнээс уг хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно”, 18.4-т “Энэ хуулийн 8.1.2-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс уг орлогыг олохтой холбогдон гарсан энэ хуулийн 13.1-д заасан нөхцөлийг хангасан зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно”, 18.5-д “Энэ хуулийн 10.1.4-т заасан биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг уг хөрөнгийн борлуулсан, шилжүүлсэн орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хасаж тодорхойлно” гэж тус тус заасан байна.

14. Нэг. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Доор дурдсанаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж зааснаар татварыг тогтоох, өөрчлөх, хөнгөлөх буюу буцаан олгохыг хуулиар тодорхойлох нь зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдах бүрэн эрх тул маргаан бүхий хуулийн зохицуулалтын зорилго, мөн чанарыг зөв тайлбарлахын тулд хууль тогтоогчийн хүсэл зоригийг тандах шаардлагатай бөгөөд үүнд хуулийг тайлбарлах түүхчилсэн аргыг хэрэглэх нь зүйтэй.



15.2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын 3 дахь хэсэгт “Одоогийн татварын хуулиар бүх төрлийн аж ахуйн нэгж нэгэн ижил тайлангийн маягаар, ижил хугацаанд тайлагнаж, төлдөг тул жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх, тайлагнахтай холбогдсон зардлууд хүндрэл учруулдаг. Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах, тайлагналын ажиллагааг хялбарчлах зорилгоор хялбаршуулсан татварын тайлагнал, төлөлтийн заалтуудыг хуулийн төсөлд тусгалаа. Үүний дагуу ... жилийн борлуулалтын орлого 1.5 тэрбум төгрөгөөс доош аж ахуйн нэгжүүдийн төлсөн татварын 90 хувийг хөнгөлөхөөр хуулийн төсөлд тусгалаа” гэж; 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх төсвийн байнгын хорооны санал дүгнэлтэд “... 300 саяас 1.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого олсон бол төлсөн татварынхаа 90 хувийг буцаан авахаар тусгалаа” гэж тус тус дурджээ.

16.Дээрхээс дүгнэвэл, хууль санаачлагчийн хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлсэн үндсэн зорилго нь жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, татварын ачааллыг бууруулахад оршиж, уг дэмжлэгийг борлуулалтын болон үйл ажиллагааны орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй аж ахуйн нэгжид олгохоор зорьжээ.

17.Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад татварын буцаан олголтын талаарх зохицуулалтын төсөлд зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас хууль санаачлагчаас анх өргөн мэдүүлсэн “борлуулалтын орлого” гэх үзэл баримтлал хуулийн төсөлд анх тусгагдсан агуулгаараа хадгалагдан үлдэж, 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр уг хуулийг эцэслэн баталжээ.

18.Иймд, нэхэмжлэгчийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын “... Харин 2018 оны хуулийн төслийн анхны хувилбарын 22.1 дэх хэсэг нь аливаа тодруулга заалт, зохицуулалт эшлэхгүйгээр “албан татвар төлөгчийн жилийн татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, дор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө” гэсэн байсан. Эндээс үзэхэд, үзэл баримтлалын дагуу хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулахдаа, энэ хэсэгт дурдсан 1.5 тэрбумын борлуулалтын орлого гэдэг нь ААН-ийн тухайн жилийн нийт борлуулалтын орлогыг илэрхийлж байж. Харин хуулийн төслийг хэлэлцүүлгийн материалаас үзэхэд, 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Төсвийн байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 17, мөн Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төсвийн

байнгын хорооны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийн 27 дахь талд ... тус тус өөрчлөн найруулахаар тусгасан нь ... одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн 22.1 дэх хэсэгтэй таарч байна” гэх агуулга бүхий гомдол үндэслэлгүй байна.

19.Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 7.4.1-д “үйл ажиллагааны орлого”, 7.4.2-т “хөрөнгийн орлого”, 7.4.3-т “хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого”, 7.4.4-т “бусад орлого”, 7.5-д “Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдөх орлогыг хасаж тооцно” гэж албан татвар ногдох орлогыг тодорхойлжээ.

20.Түүнчлэн, хуулийн 18 дугаар зүйлийг “Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох” гэж гарчиглан, 18.1-д “Албан татвар төлөгчийн татварын жилийн албан татвар ногдуулах орлогод албан татварыг ногдуулна”, 18.2-т “Энэ хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 9.1.1, 11.1.1, 11.1.4-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс энэ хуульд заасан зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, уг орлогоос энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шилжүүлэн тооцох алдагдлыг хасаж тухайн жилийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно”, 18.3-т “Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсэн үнээс уг хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно”, 18.4-т “Энэ хуулийн 8.1.2-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс уг орлогыг олохтой холбогдон гарсан энэ хуулийн 13.1-д заасан нөхцөлийг хангасан зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно”, 18.5-д “Энэ хуулийн 10.1.4-т заасан биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг уг хөрөнгийн борлуулсан, шилжүүлсэн орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хасаж тодорхойлно” гэж тус тус албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохын тулд ямар төрлийн орлого олсноос хамааран хасагдах зардал бүрийг ялгамжтай зааглан хуульчилжээ.

21.Харин Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийг “Албан татварын хөнгөлөлт” гэж гарчиглан 22.1-д “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө.” гэж заасан бөгөөд хуулийн энэхүү бүлэглэсэн зүйлийн зорилго нь албан татварыг ямар нөхцөлд хөнгөлж болохыг хууль тогтоогч тусгайлан заасан байна.



22.Дээрхээс үзэхэд, хуулийн 18 дугаар зүйл нь татвар ногдуулах орлогыг тодорхойлоход чиглэсэн бол 22 дугаар зүйл нь харин албан татвараас хөнгөлөхөд чиглэсэн, өөр өөр зорилго бүхий зохицуулалт тул эш татсан диспозицийг үндэслэж зохицуулалтын агуулгыг тодорхойлох боломжгүй, энэ талаар дурдсан хяналтын гомдлыг хүлээн авах боломжгүй.

23.Түүнчлэн, “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар ...” гэж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлсон заалтыг эшилсэн нь хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д зааснаас бусад зохицуулалтад хамаарахгүй гэх агуулгыг илэрхийлсэн буюу өөрөөр хэлбэл, хуулийн 18.6, 18.7 ... гэх зэрэг 18 дугаар зүйлийн бусад дэд заалтад тусгасан хэсэгт хамааралгүй гэдгийг илэрхийлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг” гэж хамаарах заалт бүрийг тодорхой зааж эшилсэн гэж үзэхээр байна.

24.Гурав.Хуулийг батлан гаргах болсон хууль тогтоогчийн хүсэл зориг, хуулийн зохицуулалтын уялдаа төдийгүй хуулийн нэр томьёо, үгийн шууд утгыг авч үзэхэд өмнө дурдсан үндэслэл мөн тогтоогдож байна.

25.Тодруулбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “...албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан ...” гэж тодорхой заасан бөгөөд хасагдах зардлыг хассаны дараах дүн болох “албан татвар ногдуулах орлого” гэж хууль тогтоогч тодорхойлон заагаагүй байна. Иймд хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 7.4.1-д “үйл ажиллагааны орлого”, 7.4.2-т “хөрөнгийн орлого”, 7.4.3-т “хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого”, 7.4.4-т “бусад орлого”, 7.5-д “Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдөх орлогыг хасаж тооцно” гэж тус тус заасны дагуу албан татвар ногдох орлого гэдэгт хасагдах зардлыг бус, албан татвараас чөлөөлөгдөх орлогыг хассаны дараах нийт борлуулалт, үйл ажиллагааны орлогыг бүхэлд нь авч үзэхээр байна.

26.Гэтэл анхан шатны шүүх “... Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах үг зүйн аргын үүднээс харахад, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн гипотезэд Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг ... гэсэн байх буюу үг зүйн хувьд албан татвар ногдох орлого гэж заасан байх боловч эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах системчилсэн тайлбарын үүднээс авч үзвэл, хууль тогтоогч энэхүү хэм хэмжээний гипотез хэсэгт мөн хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5 дахь хэсгийг шууд эш татан заасан байгаагаас үзэхэд албан татвар ногдох орлого бус,

харин албан татвар ногдуулах орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байх нөхцөл нь албан татварын хөнгөлөлт эдлэх эрх үүсгэхээр байна” гэж дүгнэсэн нь үндэслэлгүй буюу хуулийн зохицуулалтын зорилго, хоорондын уялдаа болон нэр томъёог зөв тайлбарлаагүй, хууль тогтоогчийн хүсэл зоригийг анхаараагүйг дурдах нь зүйтэй.

27.Харин давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ “... хуулийн тодорхой заалтаар аж ахуйн нэгжийн тухайн жилийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байгаа тохиолдолд тухайн татвар төлөгчийн ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө гэж зохицуулсан бөгөөд нэхэмжлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-ийн албан татвар ногдох орлого 1,901,639,771.79 төгрөг буюу хуульд заасан 1.5 тэрбум төгрөгийг давсан байгаа энэ тохиолдолд ногдуулсан татварын 90 хувиар татварын хөнгөлөлт эдлэх хууль зүйн үндэслэлгүй ... Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2-т ... тухайн жилийн албан татвар ногдуулах орлогыг хэрхэн яаж тооцохыг тодорхойлсон байна. Харин мөн хуулийн 22.1-д ... албан татвар ногдох орлогын дүнг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан гэж тодорхой заасан байх тул тухайн аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байх тохиолдолд ногдуулсан татварын 90 хувиар татварын хөнгөлөлт эдлэхээр байна” гэж дүгнэн маргаан бүхий заалтыг хуулийн бусад зохицуулалттай харилцан уялдаанд авч үзсэн нь зөв боловч хууль тогтоогчийн хүсэл зоригийг тандах буюу хууль тайлбарлах түүхчилсэн аргыг анхаараагүйг дурдах нь зүйтэй.

28.Тиймээс энэ талаар тодруулж, нэхэмжлэгчийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.1-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 221/МА2025/0591 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгч “Өмгөөллийн Эм Ди Эс энд хаанлекс” ХХН-ийн төлөөлөгч Ж.Майзориг, өмгөөлөгч С.Батбуян нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасныг баримтлан нэхэмжлэгчийн төлөөлөгч хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.



Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА

ШҮҮГЧИД

Г.БАНЗРАГЧ

Д.БАТБААТАР

Ц.ЦОГТ

М.БАТСУУРЬ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.75

Индекс: 200003